

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY


2016 оны 06 сар №11 (113)

mongolianeconomy.mn

Э.Тэмүүлн: Хотын хөгжлийг
шинэ түвшинд гаргана

Сонирхол татахын тулд хүчтэй
дэд бүтэцтэй байх хэрэгтэй

Хөгжил авчрах аж үйлдвэрийн паркууд



УЛААНБААТАР
ХОТЫН ХӨГЖЛИЙН
КОРПОРАЦИ ХК



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН
14 ХОНОГ ТУТМЫН АНГЛИ, МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ СЭТГҮҮЛ

Mongolian Economy

www.mongolianeconomy.mn

Утас: 94092904, 88006228, 70115476, 70115477
И-мэйл: info@mongolianeconomy.mn

**MONGOLIAN
ECONOMY**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999 4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800 6228/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Баранжав /9409 2904/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:
Б.Үүрийнтуяа
Б.Энхцэцэг
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь


Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
I хороо, Экспресс тауэр. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476

15160 Улаанбаатар,
Төв шүүдэн, ш/ х-2762

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн:
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дахь салбарууд

 [facebook.com/
Mongolian.Economy](https://www.facebook.com/Mongolian.Economy)

 [twitter.com/
EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)

 [youtube.com/user/
MongolianEconomy](https://www.youtube.com/user/MongolianEconomy)

Эдийн засаг

**6 Аж үйлдвэрлэл
Улаанбаатарт**

Аж үйлдвэрийн паркуудтай болчихвол Улаанбаатарт төдийгүй улсын эдийн засагт ихээхэн тустай юмсанж.

8 “Та бүхэнтэй хөтөлцөхөөс өөр сонголт бидэнд байхгүй”

Японы ядуурлын сан, Канадын зүгээс бидэнд тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгааг уламжлахад таатай байна.

9 Э.Тэмүүлн: Хотын хөгжлийг шинэ түвшинд гаргана

Энэ удаагийн форумын зорилго нь аж үйлдвэрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийн талаар бизнесийнхэнд болон бусад холбогдох талуудад мэдээлэл өгөх, сурталчилах, хөрөнгө оруулалт татах зориулттай зохион байгуулж байгаа юм.

11 Төслийн танилцуулга

Зарим төслүүдийн баримт бичиг ирэх зургаан сарын хугацаанд бэлэн болох төлөвтэй байна

15 Т.Чимэгсанаа: Паркуудын хөгжилд хувийн хэвшлийн манлайлал чухал

Олон улсын жишгийг харахад аж үйлдвэрийн паркийг хөгжүүлсэн гурван өөр туршлага байна.

17 Төслийн санхүүжилтийг ахисан түвшинд гаргах нь

Бизнес хэдий өндөр эрсдэлүүд байдаг ч төслийн санхүүжилтийн хувьд азаа

үзнэ гэдэг үхлээ эрсэнтэй адил.

18 Mongolian Economy сэтгүүлийн асуулт

19 Сонирхол татахын тулд хүчтэй дэд бүтэцтэй байх хэрэгтэй

Уул уурхайн салбарт зах зээл эргэж, тавааруудын ханш тааруу болсноос үүдэн бид зарим хүндрэлүүдтэй нүүр тулгарч байгаа.

22 Дэлхийн аж үйлдвэрийн сонин хачин

Аж үйлдвэр Америкийн эдийн засгийг хөдөлгөхөө больсон байж болох ч тус улсын олон хэсэгт эл салбарын өсөлт хүчтэй хүчин зүйл хэвээр байна.

24 Жеймс Робинсон: Институци гэдэг барилга барьж, түүнийгээ хүмүүсээр дүүргэнэ гэсэн үг биш

Монгол Улсын хувьд байгалийн баялгаа хүн бүрт хүртээмжтэй байлгах зорилго бүхий институцийг бүтээх хэрэгтэй. Ийм шаардлага байгааг харуулж буй маш олон баримт байна.

28 Гадаад худалдаанд гарсан ахиц

Баян орнууд гэрэлтэж байна

Монголын эдийн засаг гадаад худалдаанаас, харин гадаад худалдаа маань Хятадын зах зээл, тийшээ нийлүүлэх ашигт малтмалын үнэ ханшаас



Аж үйлдвэрлэл Улаанбаатарт

хотын хог хаягдал улам ихэсч өдөрт 3000 хүртэлх тонн хог хогийн цэгийг “зорьдог” аж. Энэ тоог жилээр авч үзвэл 950 мянган тонн болдог гэх, хуудас 6



Э.Тэмүүлн: Хотын хөгжлийг шинэ түвшинд гаргана

Батлан даалтын сан шиг тийм зүйл хийчихвэл заавал Засгийн газрын баталгаа гэхгүй тухайн төсөл хэрэгжээд явах боломжтой болно, хуудас 9




Т.Чимэгсанаа: Паркуудын хөгжилд хувийн хэвшлийн манлайлал чухал

Парк байгуулж хөгжүүлэх үндсэн гурван чиглэл бий, хуудас 15



Дэлхийн аж үйлдвэрийн сонин хачин

Парк байгуулж хөгжүүлэх үндсэн гурван чиглэл бий, хуудас 22



ДЭЛХИЙ ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.
Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.
ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг уг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг. Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904

Редакцийн зурвас

Манай сэтгүүлийн зүгээс Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь амьдардаг их хотынхоо хөгжлийг гэрэлт ирээдүй тосож байгаа гэдэгт итгэдэг. Тиймээс нийгэмд дөрөвдэгч засаглалын үүрэгтэй хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд Улаанбаатар хотын хөгжил цэцэглэлтэд өөрийн хувь нэмрийг оруулах ёстой гэж боддог. Энэ зорилгын үүднээс манай редакци өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай ойр дотно хамтарч ажиллаж, Улаанбаатар хотын эдийн засаг, хөгжил цэцэглэлт, хөрөнгө оруулалттай холбоотой тав дахь дугаараа ийнхүү таны гарт хүргэж байна.

Улаанбаатар хотын худалдааны танхим байгуулагдаад өнгөрсөн оны дөрөвдүгээр сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтарч анхны “Хөгжлийн төлөө түншлэл” нэртэй форум хийх үеэр бид уг хурлын зорилго, агуулгыг сэтгүүлийнхээ хуудсуудад буулгаж байсан бол энэ удаа “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци”-тай хамтарч сэтгүүлээ гаргаж байгаадаа баяртай байна.

Шинэхэн байгуулагдсан ч хотыг хөгжүүлэх

аж үйлдвэрийн том төслүүдийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж буй тус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, бид хамтдаа үйлдвэрлэл хөгжсөн, агаарын бохирдол багатай, ая тухай орчинтой ногоон хоттой болохыг зорьж байгаа хэрэг.

Аж үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлогыг Улаанбаатар хотын хөгжилтэй уялдуулж, нөгөө талаасаа хувийн хэвшлийг дэмжиж хамтдаа урагшлах гэсэн дээрх корпорацийн бодлого бизнесийнхэнд хэрхэн буух вэ, тэд юуг зорьж чиглэж байна вэ гэдгийг энэ удаагийн дугаартаа дэлгэрэнгүй харуулахыг зорилоо.

Манай сэтгүүлээс та бүхэн төр хувийн хэвшлийн түншлэлээр Улаанбаатарын том төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх ямар боломж байгаа юм бэ гэдгийг харж болно. Нэг үгээр хэлбэл, Улаанбаатар хотын хөгжлийн корпорацийн зүгээс хувийн хэвшлийнхэнд өгөх гэсэн мэдээллийг хүргэх гүүрийн үүргийг бид гүйцэтгэж байна. Таалан болгооно уу.

“MONGOLIAN ECONOMY”

Төсөл

Аж үйлдвэрлэл Улаанбаатарт

Б.ҮҮРИЙНТУЯА

Нийслэлийн дагуул хотуудыг дагуулдаг хот болгох талаар нэлээд олон жил ярьж байгаа ч өнөөг хүртэл хэрэгжсэн зүйл үгүй. Аж үйлдвэрийн паркуудтай болчихвол Улаанбаатарт төдийгүй улсын эдийн засагт ихээхэн тустай юмсанж. Тиймээс Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (УБХК)-иас “Улаанбаатарын хөгжил 2016: Аж үйлдвэрийн паркууд, тэдгээрийн дагаж хэрэгжих төслүүд” бизнесийн форумыг зохион байгуулж буй. Энэ хүрээнд аж үйлдвэрийн паркууд байгуулах нэг бус төсөл гарчээ. Тодруулбал, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”, “Эмээлтийн хөнгөн үйлвэр, технологийн парк”, “Налайхын барилгын материалын худалдааны төв”, Нарангийн энгэр, Цагаан давааны хогийн цэгүүдэд барих “Эко Парк” гэх мэт төсөл хөрсөнд буухаа хүлээж буй аж. Эдгээр

нь УБХК-иар дамжин хэрэгжихээр төлөвлөгджээ. Тодруулбал УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” болон “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратеги” зэргийн хүрээнд дээр дурьдсан төслүүдийг хэрэгжүүлэхээр тогтжээ. Эдгээрт 769 тэрбум төгрөг шаардлагатай гэдгийг тус корпорацийн танилцуулах хуудаст бичсэн байна. Дээрх паркуудад шаардлагатай санхүүжилтийг Улаанбаатар хотын хөгжлийн корпорацийн зүгээс хувийн хэвшилтэй хамтран хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжтой юм байна. Нийслэлд эдийн засгийн зургаан салбар идэвхтэй үйл ажиллагаа

явуулж буй нь бөөний, жижиглэнгийн худалдаа, ил болон далд уурхай, бага дунд хэмжээний нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл төдийгүй үл хөдлөх хөрөнгийн, санхүүгийн болон даатгалын салбар юм. Эдгээр нь нэмүү өртөг шингэсэн улсын ДНБ-ий 60 гаруй хувийг эзэлдэг талаар өнгөрсөн жил хэвлэгдсэн “Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжлийн стратеги”-д тусгасан байна. Сүүлийн таван жилийн хугацаанд хотын эдийн засаг 9.5 хувийн өсөлт үзүүлсэн байна. Энэхүү үзүүлэлтийг цаашид улам бүр нэмэгдүүлэхэд аж үйлдвэрийн паркууд төдийгүй тэдгээрийн даган хөгжих бусад салбар чухал үүрэгтэй аж. Гэвч одоогоор төслийн бэлтгэл ажлууд дөнгөж эхэлж буй бөгөөд урьдчилсан ТЭЗҮ, хэсэгчилсэн төлөвлөгөө, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ зэрэг анхан шатны ажлуудыг хийж буй ▶



► гэдгийг форумыг зохион байгуулж буй ажлын хэсгээс тайлбарлалаа. Уг ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ даргалж байгаа бол нарийн бичгээр УБХК ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Тэмүүлэн ажиллаж байгаа аж.

Нийслэлийн захиргааны одоогийн удирдлагууд болон нэг хэсэг хувийн хэвшлийнхний сэтгэл зүтгэл тавьж буй аж үйлдвэрийн паркуудын төсөл бүрэн биш юмаа гэхэд нэгээхэн нь хэрэгжээд эхлэх юм бол Улаанбаатар хот 2030 он гэхэд танигдахын аргагүй хөгжих нь. Эдийн засгийн хувьд хангалттай солонгорсон орлогын эх үүсвэртэй болохоос гадна дэд бүтцийн салбарт дорвитой өөрчлөлт гарах юм. Төслүүдийн танилцуулгад төслийн зорилго болон хамрах хүрээ, шаардлагатай хөрөнгө оруулалт, эргэн төлөлт, хувийн хэвшлийн оролцоо гээд чухал байж болох бүхий л мэдээллийг багтааснаараа онцлогтой. Эдгээр төслийг хэрэгжүүлэхээр зорьж буй тус корпораци цаасанд бууж болох мэдээлэл бүрийг нарийвчлан гаргасан төдийгүй англи хэл дээр бэлтгэсэн нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татах гэсэн сайн оролдлого гэж үзэж байна.

Нэр дурьдагдаж буй төслүүд дунд “Эко парк” ихээхэн сонирхол татна. Байгаль, экологийн асуудал дэлхий нийтийн хамгийн их ярьдаг сэдэв болж байгаа энэ үед Монгол Улс хөгжиж буй орны хувьд экологид чухал ач холбогдол өгч, алсын хараагаа болгож байгааг онцлох хэрэгтэй. Түүнчлэн манай улсын хүн амын дийлэнх амьдарч буй Улаанбаатар хотын иргэд жил ирэх тусам өссөөр байгаа билээ. Ийм нөхцөлд хотын хог хаягдал улам ихэсч өдөрт 3000 хүртэлх тонн хог хогийн цэгийг “зорьдог” аж. Энэ тоог жилээр авч үзвэл 950 мянган тонн болдог гэх. Ийм байтал дахин боловсруулах үйлдвэрлэл манай хотод бүү хэл улсад хөгжжөөгүй хэвээр байгаа юм. Энэ үүднээс авч үзвэл хог хаягдлын менежментийг сайжруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, түүнчлэн ил задгай хог хаях явдлыг таслан зогсоох чухал шаардлага тулгарч буй. Ингээд үзвэл “Эко Парк”-ийн санаачилга нүдээ олсон шийдэл байх магадлалтай. Олон жил ярьж улиг болсон энэ асуудал хэрвээ хэрэгжих юм бол шүү дээ. Хэрэгжих үндэслэл нь хотын удирдлагын зүгээс

хэрэгжүүлэхээр санаачилан, дэмжиж буй төслийн тоонд орж, цааснаа буусанд буй. Тус паркийн гол зорилго хог ангилах, дахин боловсруулах, ингэхдээ байгальд болон эдийн засагт хамгийн ээлтэй технологийг ашиглахад чиглэх аж. Хоёр үндсэн байршилд байх уг парк дахин боловсруулах 12 үйлдвэр, дэд бүтцийн таван байгууламжийг Нарангийн энгэрийн таван километр зам дагуух 174.6 га газарт сүндэрлүүлэх гээд хамрах хүрээ өргөнтэй төлөвлөсөн байна. Төсөлд шаардагдах хөрөнгө оруулалтыг 246 тэрбум төгрөг, эргэн төлөгдөх хугацаа 9.8 жил байхаар

тооцож 2020 онд бүтээн байгуулалтын ажлыг дуусгана хэмээн танилцуулжээ.

Энэ мэтчилэн хэрэгжих хүлээлттэй байгаа 10 гаруй төсөл ээлжээ “хүлээж” байна. Хийхээс бусдыг нь хийчихсэн хариуцсан байгууллага нь санхүүжилттэй нүүр тулж буй. Өнгөрсөн жилийн “УБ Форум”-аар нийслэлийг Азийн санхүүгийн төв болох ирээдүйтэй хэмээн ярьцгааж байсан. Тэгвэл өдгөө хэлэлцэж буй цаасан дээр бичсэн төслүүд амьдралд буувал Улаанбаатар хот Азийн хэмжээнд яригдах эдийн засаг, санхүүгийн төв болох эхлэлээ зөв тавьж байна гэх үндэслэл бүрдэх юм. ■



Эмээлт” хөнгөн үйлдвэрийн парк

**Улаанбаатар хотын эдийн засагт
Улаанбаатарын хөгжлийн корпорацийн үзүүлэх нөлөөлөл**



Эшлэл

“Та бүхэнтэй хөтлөлцөхөөс өөр сонголт бидэнд байхгүй”



Э.БАТ-ҮҮЛ: Хөгжлийн корпораци нь захиргааны байгууллагын зангаар хувийн хэвшилээ хулхиддаг, эзний сэтгэлгээгээр ханддаг, захиргаадаж, хүнд суртал гаргадаг байж болохгүй

“Mongolian Economy” сэтгүүлд өгсөн ярилцлагаас эшлэв

Нийслэлийн Захирагч буюу Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ТУЗ-ийн дарга Э.Бат-Үүлийн өнгөрөгч нэгдүгээр сард тус хөгжлийн корпорациас зохион байгуулсан хурлын үеэр хэлсэн үг:

-Миний бие та бүхэнтэй өмнө нь уулзсан уулзалтын дараа бидний хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой арга хэмжээ болох Парисын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн 21 дэх чуулганы Хотуудын дарга нарын уулзалтад оролцоод ирлээ.

Юуны өмнө та бүхэнд нэг сайхан мэдээ дуулгая. Тэр нь юу гэхээр тус чуулга уулзалтын үеэр ногоон хөгжлийг дэмжиж нийтдээ 100 тэрбум ам.доллар зарцуулахаа зарласан. Энэ эх үүсвэрээс хамгийн гол нь төр хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийг санхүүжүүлэх чигтэй байгааг энд тэмдэглэн хэлэх байна. Тэр үеэр бид АХБ-ныханд Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлалаа танилцуулаад, ногоон хөгжлийн чиглэлээр юу хийх гэж байгаа тухайгаа тодорхой мэдээлэл өгч, санал солилцсон. АХБ –ны зүгээс бидэнд олон улсын санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцсэн арга зүйг суулгахад ихэвчэн туслалцаа үзүүлж байгаа учраас талархлаа илэрхийлье. Мөн Японы ядуурлын сан, Канадын зүгээс бидэнд тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгааг уламжлахад таатай байна.

Тэгэхээр дэлхийн дулаарлын эсрэг үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах ийм бизнес төсөл байвал мөнгө бол байна. Гэхдээ тэр мөнгөний гол үндсэн шаардлага нь төр хувийн хэвшлийн түншлэл чухал гэдгийг Парист улиг болтол ярьсан. Тийм учраас та бүхэнтэйгээ хөтлөлцөхөөс өөр сонголт бидэнд байхгүй гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Та бүхэнтэй хамтарч ажиллах Улаанбаатар хотын корпорацийг бид байгуулсан. Үйл ажиллагаа нь эхэлчихсэн байгаа. Одоо бол шууд төслүүд рүүгээ орно. Бид хөтлөлцөөд гүйвэл маш их боломж байна. Мэдээж хэрэг дээрх нь дэлхийд зориулах гэж байгаа мөнгө. Гэхдээ Улаанбаатар Төв Азийн өндөрлөг дэх хүлэмжийн хий ялгаруулж байгаа том яндангийн нэг нь болчихоод байна. 200 мянган яндан утаа гаргаж байгаа учраас агаарыг маш ихээр бохирдуулж байгаа. Тийм учраас манайд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна гэдгээ Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын байгууллагынхан хэлсэн. Бидэнд боломж байна. Тэр мөнгийг л нийслэлийн хөгжилд татаж авчрах зөв бодлого, бодитой алхам хийх нь чухал. ■

Хөгжил

Э.Тэмүүлн: Хотын хөгжлийг шинэ түвшинд гаргана

“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Тэмүүлнтэй тус корпорацийн үйл ажиллагааны талаар болон хотын үйлдвэрлэл, технологийн паркуудын асуудлаар ярилцлаа. Тэрбээр 2013 оноос Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газрын даргаар ажиллаж байх хугацаандаа “Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн стратеги”-ийн баримт бичгийг боловсруулжээ. Тэмүүлн өдгөө өөрийн боловсруулсан эдийн засгийн стратегийг хэрэгжүүлэхээр “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци”-ийг удирдан ажиллаж байна.

-Энэ удаагийн Улаанбаатар хотын хөгжлийн корпорациас хийж байгаа бизнес форумын онцлог ач холбогдол юу вэ?

-Корпораци УБ хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд суусан төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд жил бүр бизнес форум зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байгаа. Энэ удаагийн форумын зорилго нь аж үйлдвэрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийн талаар бизнесийнхэнд болон бусад холбогдох талуудад мэдээлэл өгөх, сурталчилах, хөрөнгө оруулалт татах зориулттай зохион байгуулж байгаа юм.

-Улаанбаатар хотын хөгжлийн корпораци байгуулагдах болсон үндэслэл юу вэ?

-2013 онд УИХ-аар баталсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тулгуурлан миний бие өмнө нь Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газрын дарга байхдаа багийнхаа хамт “Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжлийн стратеги”-ийг боловсруулж НИТХ-



аар батлуулсан. Ямар ч улс, хот өөрийн гэсэн урт хугацааны стратеги, зорилттой байдаг. Түүний дагуу л явж байна. Бид юу хийсэн гэхээр хамгийн эхлээд Улаанбаатар хотын худалдааны танхимыг байгуулсан. Дэлхийн хаана ч ямар ч хотод очсон тухайн хотын танхим гэж байдаг. Манайх шиг 1.3 сая хүн амтай нийслэлийн хувьд Хотын танхимгүй байна гэдэг байж болшгүй

зүйл. Мөн бид эдийн засгийн олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сэтгэл шулуудсан. Төслүүдийг Нийслэлийн эдийн засгийн газар хэрэгжүүлэх нь учир дутагдалтай байсан. Хамгийн наад зах нь тус газар захиргааны байгууллага учраас бизнесийн харилцаанд орох боломжгүй. Тиймээс хотын эзэмшлийн компани байгуулах хэрэгтэй юм байна гээд бид нийслэлийн хэмжээнд хаалттай ▶

▶ ХК байгуулсан. Ингэснээр бидэнд судалгаа, тооцоо хийх хувийн хэвшлийн сайн боловсон хүчинг өндөр цалинтай авч ажиллуулах боломж нээгдсэн.

-Танай байгууллагын гол зорилт юу вэ?

-Би дээр Улаанбаатар хотыг хөгжүүлэх хоёр бодлогын баримт бичгийг дурдсан. Тэгэхээр энгийнээр хэлэх юм бол хотын хөгжлийг хөгжингүй орнуудын түвшинд аваачихад хотын захиргааны зүгээс хийсэн байх ёстой төсөл хөтөлбөрүүдийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх зорилготой. Одоо байгаа төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж гээд 2020 он хүртэл тооцоолоод үзэхээр 25.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байх жишээтэй. Ийм хэмжээний мөнгө Засгийн газарт ч байхгүй, нийслэлд ч байхгүй. Тэгэхээр бид хөрөнгийг зайлшгүй хувийн хэвшилтэй, санхүүгийн сектортой хамтарч босгох шаардлагатай болж байгаа. Гэхдээ өөрсдөө босгохгүй дандаа оролцогч талуудтайгаа голчлон хувийн хэвшилтэйгээ хамтарна. Тэгэхийн тулд төр хувийн хэвшлийн түншлэлээр хийнэ. Монголд 2010 онд Концессын тухай хууль баталсан байдаг. Гэхдээ тэнд учир дутагдалтай зүйл бишгүй бий. Бид төр хувийн хэвшлийн түншлэлийг олон улсад хэрхэн хэрэгжүүлдэгийг Улаанбаатар хотын корпорациар дамжуулж хийнэ.

-Танай корпорацийн ТУЗ-д төр, хувийн хэвшлийн төлөөлүүд ижил тэнцүү тоотой орсон байсан. Энэ нь та бүхний хийх ажил, компанийн зорилготой холбоотой юу?

-Манайх Төлөөлөл удирдах зөвлөлөө байгуулахдаа шинэ тогтолцоо бий болгохыг зорьсон. Тэр нь юуг хэлж байгаа гэхээр ТУЗ-ийн есөн гишүүний гурав нь хотын захиргааны төлөөлөл, мөн тооны гишүүн нь Хотын худалдааны танхим буюу хувийн хэвшлийн, үлдсэн гурав нь Компанийн тухай хуулийн дагуу хараат бус гишүүн. Хараат бус гишүүдийн хувьд ТББ болон их дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн байгаа. Энэ байгууллагын бүх ажил бизнесмэнүүдийн санал санаачилгаар явах учраас Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг нь хувийн хэвшлийн төлөөлөл байлгахыг чухалчилсан.

Бид хөгжлийн корпорацийг өөрсдөө

бодоод зохиочихсон юм биш. Дэлхийн ихэнх томоохон хотуудад манайх шиг статустай /янз янзаар нэрлэсэн байдаг/ хөгжлийн асуудал хариуцсан компани байдаг. Түүгээр дамжуулж бизнесийнхэнд ч ашигтай, хотын захиргаанд ч ашигтай тогтолцоог бий болгосон байдаг. Тэрийг манайх одоо л нэвтрүүлж байна.

Э.Бат-Үүл дарга Улаанбаатар хотыг амьдрахад ээлтэй хот болгох, бидний үр хүүхдүүдийг сайхан хотод амьдраасай гэдэг зорилготой ажиллаж байгаа. Тэгэхийн тулд ажлын байр бий болгох шаардлагатай. Харин аж үйлдвэр хамгийн их ажлын байр бий богиног. Аж үйлдвэрийн паркууд баригдаж байж хот маань маргааш биш юмаа гэхэд тодорхой хугацааны дараа ажиллах, амьдрахад таатай хот болно. Хотын эдийн засгийг хөгжүүлэх төслүүдийн механизмыг илүү сайжруулж шинэ түвшинд гаргана.

Хотын дарга нийслэлийн ажилчиддаа байнга хэлдэг нэг үг бий. “Ажилдаа хоноцны сэтгэлээр бүү ханд, энэ чинь та нарын үр хүүхдүүд амьдрах хот шүү дээ, хүүхдүүдийхээ зургийг ширээн дээрээ тавь” гэж. Одоо миний ширээн дээр манай охины дөрвөн зураг байгаа.

-Корпорацийн бизнес төлөвлөгөөнд туссан ойрын зорилт юу вэ?

-Хотын хөгжил цэцэглэлттэй холбоотой эдийн засгийн төсөл хөтөлбөр асуудалгүй хэрэгждэг тогтолцоог нутагшуулах нь чухал. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийнхэн хотын захиргаатай бизнес хийхэд айдаггүй болдог тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй. Мөн бид Хөгжлийн сан байгуулж төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийдэг, төсөл хөтөлбөрүүдийн ашгаас хөгжлийн сангаа зузаатгадаг, шаардлагатай үед хөрөнгийн баталгаа гаргадаг механизм бүрдүүлэхээр ажиллаж байна. Одоо бол төсөл хэрэгжих гэхээр Засгийн газрын юм уу, нэг бол Хөгжлийн банкны баталгаа шаарддаг. Гэтэл тэр нь улсын өрийн таазанд тулаад явдаггүй. Тэгэхээр бид өөрсдөө манайд хэвшсэнээр яривал Батлан даалтын сан шиг зүйл хийчихвэл заавал Засгийн газрын баталгаа гэхгүй тухайн төсөл хэрэгжээд явах боломжтой болно.

-Тухайлбал, энэ удаагийн хурлаар хотын аж үйлдвэрийн паркуудын тухай ярилцах гэж байна. Энэ

чиглэлд цөөнгүй төсөл хөтөлбөр бий. Үүнийг хувийн хэвшилтэй хамтран хийхийн тулд Улаанбаатар хотын корпорацийн зүгээс үзүүлэх дэмжлэг, оролцоо юу байх вэ?

-Улаанбаатар хотод хөрөнгө оруулалтыг татаж, мега төслүүдийг хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлэхийн тулд л манай корпорацийг байгуулсан шүү дээ. Тиймээс манайх нийслэлийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх төсөл хөтөлбөрүүдийг авч, дэмжиж хамтарч ажиллах юм. Жишээ нь Налайх хотын барилгын үйлдвэрлэл технологийн парк байлаа гэхэд бид дэд бүтцийн асуудлыг шийдэх, нийслэлийн засаг захиргаанаас шалтгаалах бусад бүх дэмжлэгийг бизнесмэнүүдэд үзүүлнэ. Шаардлагатай хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилтэй хамтраад босгоно. Гэтэл өнөөдөр бизнес эрхлэгчид газар олж авах гэж маш их цаг, мөнгө гарздаж байна. Түүнчлэн хотын захаар хэнийх нь мэдэгдэхгүй, ямар зориулалтаар ашиглах гэж байгаа нь тодорхойгүй том том газрыг хашаажуулсан байх нь элбэг. Энэ байдал бол хотын хөгжилд сайн нөлөөтэй зүйл биш.

-Аж үйлдвэрийн технологийн паркуудын төслийг амжилттай хэрэгжүүлснээр гарах үр дүнгээс та товч дурдахгүй юу?

-Өнөөдрийн түвшинд Улаанбаатарын аж үйлдвэрлэл, технологийн паркууд гэсэн нэршил оновчгүй байж ч магадгүй. Жишээ нь хотын зүүн талд нэгдсэн логистикийн төв байгуулах гэж байгаа. Үүнийг хийснээрээ хамгийн наад зах нь хотын замын түгжрэл, тоосжилт эрс багасна. Манай Улаанбаатар хотын төмөр замыг дагаад арваад терминал байдаг. Тэр бүгдийг хотоос гаргана гэсэн үг. Мөн гэр хорооллыг орон сууцжуулах хүрээнд их хэмжээний барилгын материал импортолж, доллар гадагшаа урсгахын зэрэгцээ маш их агаарын бохирдолтой болж байна. Тэгвэл Налайхад барилгын материалын үйлдвэрлэлийн парк байгуулж тэр их хэрэгцээнийхээ тодорхой хувийг нь ч гэсэн дотооддоо үйлдвэрлэдэг болмоор байна. Нарангийн энгэр, Цагаан давааны хогийн цэгт дахин боловсруулах “Эко парк” байгуулах төсөл бий. Энэ мэтчлэн аж үйлдвэрийн олон төсөл байгааг хий хоосон яриа төдий үлдээх биш, хийж хэрэгжүүлж л гэж ажиллаж байна даа бид. ■

Төслийн танилцуулга

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд багтсан томоохон дэд бүтцийн төслүүд нь агаар болон усны бохирдол, замын түгжрэл зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үүднээс бий болсон. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх нь Улаанбаатар хотын нийгэм, эдийн засаг болон байгаль орчны хэтийн төлөвт ихээхэн нөлөөлөх юм. Төслүүд найман мега төслөөс бүрдэх

бөгөөд төсөл тус бүр дор хаяж 300 сая ам.долларын санхүүжилт шаардаж буй. Бэлэн байдлын үнэлгээний хувьд ихэнх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох загвар болон зураг бэлэн болсон. Зарим төслүүдийн баримт бичиг ирэх зургаан сарын хугацаанд бэлэн болох төлөвтэй байна. Тэдгээрийн зарим төслийн танилцуулгыг товчлон хүргэе.

ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК

ТОЙМ

Хөдөө аж ахуйн яамны мэдээллээр нийт боловсруулалтын 80 хувь буюу 8.0 сая ширхэг арьс шир хагас боловсруулагдаж буй аж. Энэ нь хөнгөн үйлдвэрийн цогцолбор кластер хөгжүүлэх шаардлага буйг харуулж байна.

Хотын захиргаа “Эмээлт”-д хөнгөн үйлдвэр технологийн парк барьж, арьс ширний үйлдвэрүүдийг хотоос гаргахаар төлөвлөж байна. Ингэснээр төв цэвэрлэх байгууламжийн ачаалал буурч, Туул гол руу шууд цутгаж буй бохир усны хэмжээг багасгах зорилготой юм.

ЗОРИЛТ

- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- 3500 ажлын байр бий болгох

Эмээлт тосгон, Эмээлтийн ойролцоох шинэ бүтээн байгуулалтын бүс болон Эмээлтийн аж үйлдвэрийн паркаас бүрдэнэ. Эмээлтийн аж үйлдвэрийн паркын бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар парк болон Аргалант тосгонтой залгаа жижиг бүс нутгуудыг Эмээлт аж үйлдвэрийн парк доторх үйлдвэрүүдийн ажилчдад зориулсан орон сууцны хороолол болгон шинээр хөгжүүлнэ гэсэн нь бүтээн байгуулалтын төлөвлөгөөний нэгээхэн хэсэг юм.


Паркийн бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шат, 2016-2017: Арьс ширний үйлдвэрүүд 50%, ноолуурны үйлдвэрүүд 20%

- Паркын бүтээн байгуулалтын II үе шат, 2017-2018: Арьс ширний үйлдвэрүүд 100%, ноолуурны үйлдвэрүүд 100%

- Бүтээн байгуулалтын III үе шат, 2018-2020: Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүд

- Эмээлтийн аж үйлдвэрийн паркд хоёр байгууламж багтана. Үүнд:

Аж үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж нь гурван цэвэрлэх байгууламжтай байх бөгөөд паркын бохир усны гаргалтаас хамаарч үе шаттайгаар баригдана.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нийт хөрөнгийн зардал 65.8 сая евро (3-н үе шаттай)
Өнөөгийн цэвэр өртөг 30.71 сая евро

ТӨСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

ТЭЗҮ хийгдсэн
Ерөнхий төлөвлөлт хийгдсэн
Техникийн зураг төсөл-хийгдэж байгаа
Бэлэн байдлын оноо (0-4) 2.9

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛБЭР

- Уг төслийг хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллага болон төр-хувийн хэвшлийн түншлэлээс санхүүжүүлэх болно.
- Техник, эдийн засгийн үндэслэлд арьс ширний үйлдвэрийн барилга болон тоног төхөөрөмжид 173 тэрбум төгрөг шаардлагатай

ТӨСЛИЙН НЭГЖ

- Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК
- “Эмээлт” төслийн нэгж ▶

▶ НЭГДСЭН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ

ТОЙМ

Улаанбаатар хотын нэгдсэн тээвэр логистикийн төв нь Монгол Улсын тээврийн бодлогын дагуу хэрэгжиж байгаа бөгөөд Улаанбаатар хотоор дамжин өнгөрөх тээврийг 2016 оноос эхлэн зогсоох бодлоготой “Транзит Монгол” үндэсний хөтөлбөр зэрэг төслүүд болон Улаанбаатар хотын 2030 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг дэмжиж байгаа юм.

ЗОРИЛТ

• Худалдаа болон тээврийн логистикийн салбарт Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулж, улсын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөллийг бий болгохын тулд төвлөрсөн логистикийн системийг бий болгох (Улаанбаатар хотын нэгдсэн ачаа тээврийн логистикийн төв).

- Барааны ялгах зардлыг бууруулах
- Тээврийн менежментийг сайжруулах
- Дотоодын эцсийн зардлыг бууруулах

Улаанбаатар хотын нэгдсэн тээвэр логистикийн төв нь дараах ачааны нэгжүүдийг хариуцах чадвартай байхаар төлөвлөгдсөн:

- Чингэлэгүүд (үүнд давхарласан чингэлэг багтахгүй)
- Ачааг бөөнөөр зөөх вагон
- Хүнд тоног төхөөрөмж болон машин механизмыг зөөх зориулалттай задгай вагон
- Гаалийн баталгаат болон баталгаат бус агуулах
- Гаалийн болон улсын мэргэжлийн хяналт
- Бие даасан лаборатори
- Бөөний болон үзэсгэлэн худалдааны танхим
- Байгаа терминалуудын хариуцсан хэмжээг нэгтгэх

Ачаа тээвэрлэгчид гуравдагч болон дөрөвдөгч талын логистикийн үйлчилгээнд нэвтэрнэ (3PL 4PL): ингэснээр Улаанбаатар хотын нэгдсэн тээвэр логистикийн төв багцлах, задлах, сав баглаа боодол, шошго болон агуулахтай холбоотой бизнесийг санал болгоно.

ЭРХ ЗҮЙН АКТ

Нийслэлийн Засаг даргын 512 дугаар тогтоолоор 130 га газрыг тус төсөлд олгосон

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ӨГӨӨЖ

Шаардлагатай хөрөнгө оруулалт	Эхний шатанд 120 сая ам.доллар шаардлагатай (Нийт хөрөнгийн зардал болох 219 сая ам.долларыг аажмаар хөрөнгө оруулах болно)
Санхүүжилтийн сонголт	Хувийн хэвшил, төр-хувийн хэвшлийн түншлэл
Төслийн эргэн төлөлт	6 жил
Төслийн өнөөгийн цэвэр өртөг	276 сая ам.доллар
Өгөөжийн дотоод түвшин	23%

ТӨСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

ТЭЗҮ хийгдсэн
Техникийн зураг төсөл хийгдэж байгаа
Ерөнхий төлөвлөлт хийгдсэн
Бэлэн байдлын оноо (0-4) 2.9

БАЙРШИЛ

Улаанбаатар төмөр замын Бумбат-Баян өртөөний хооронд байрлана. Налайх хотоос 10 км, Улаанбаатар хотын төвөөс зүүн тийш 34 км-ийн зайтай.

САНХҮҮЖИЛТ

Зээл, хувьцаа, төр-хувийн хэвшлийн түншлэл

ТӨСЛИЙН НЭГЖ

Туушин ХХК, төрийн болон хувийн ачаа тээвэрлэх компаниуд
Хамтарсан гэрээ-Улаанбаатар төмөр зам
Төрийн өмчийн + хувийн чингэлэг хариуцсан байгууламж
Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК ▶



▶ БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК

ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

• Тус төсөл бүх жижиг хэмжээний барилгын материалын зах, худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлж нэг цэгийн томоохон барилгын материалын цогцолборыг бий болгох зорилготой.

ЭРХ ЗҮЙН АКТ

Аж үйлдвэр, технологийн паркийн тухай хууль



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ӨГӨӨЖ

Үйлдвэрүүд	Хөрөнгө оруулалт /сая ам.доллар/	Өнөөгийн цэвэр өртөг	Өгөөжийн дотоод түвшин	Эргэн төлөх хугацаа
Бетон	33.5	14.6	25.00%	2.89
Хавтан	5.5	7.4	30.20%	2.8
Ган	5.7	4.2	22.00%	3.4
Бусад	3.05	4.9	37.00%	2.78
Нийт	47.75	31.1	28.00%	2.97
135 тэрбум төгрөг шаардлагатай				

ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛБЭР

Барих- Эзэмших-Ашиглах

ТӨСЛИЙН НЭГЖ

Хотын өмчит Налайх технологийн паркийн агентлаг
Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК ▶



▶ ЭКО ПАРК

ТОЙМ

Хотын хог хаягдал хүн амын өсөлттэй зэрэгцэн хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд одоогийн хогийн цэгүүд өдөрт 2,800-3,000 тонн хог хаягдал хүлээж авч байгаа бол жилд 850,000-950,000 тонныг хүлээж авч байгаа юм. Тиймээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хог хаягдлын менежментийг сайжруулж, мөн хог хаягдлын ангилалт болон жишиг дэд бүтэцтэй төвлөрсөн хогийн цэгийг нэвтрүүлэх шаардлагатай байна. Ингэснээр хог дахин боловсруулах байгууламжууд ашигтай ажиллах боломжтой болох юм.

Энэхүү төслөөр хог хаягдлыг эдийн засаг байгальд ээлтэй байдлаар ангилж, дахин боловсруулдаг Эко Парк аж үйлдвэрийн цогцолборыг барихаар төлөвлөж байгаа бөгөөд Нарангийн энгэр болон Цагаан даваа гэсэн хоёр үндсэн байршилд төвлөрөх аж.

ЗОРИЛТ

- Нэг цэгийн дахин боловсруулах байгууламжууд
- Нарангийн энгэр орчмын 5 км замын дагуух 174.6 га газарт 12 хог дахин боловсруулах үйлдвэр, таван дэд бүтцийн байгууламжийг барих
- Цагаан даваа орчмын 4 км замын дагуух 92.6 га газар 8 хог дахин боловсруулах үйлдвэр, таван дэд бүтцийн байгууламж барих
- Уламжлалт задгай хогийн цэгийг халж, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах
- Эрүүл бөгөөд тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх
- Шинэ ажлын байр бий болгож, шинэ байгууламжуудыг ашиглалтад оруулах
- Олон улсын стандартын дагуу зөв зохистой хог хаягдлын менежментийг нэвтрүүлэх

- Усжуулалтыг сайжруулж, ус болон агаарын бохирдлыг бууруулах

- Хог хаягдлыг дахин боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- “ICG” групп Эко Парк төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байгаа. /Байгуулах дэд бүтцүүд: Засгийн газар Наран болон Цагаан даваанд баригдах хог дахин боловсруулах байгууламжийн бүтээн байгуулалтыг хариуцах болно. 2020 он гэхэд дөрвөн хог хаягдлын менежментийн байгууламж баригдсан байна.

- Хөрөнгийн зардал 246 тэрбум төгрөг
- Өгөөжийн дотоод түвшин 23%
- Эргэн төлөх хугацаа 9.8 жил

ТӨСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ


Урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн
Ерөнхий төлөвлөлт хийгдэж байгаа
Техникийн зураг төсөл хийгдэж байгаа
Бэлэн байдлын оноо (0-4) 1.2

БАЙРШИЛ

Төвлөрсөн хогийн цэгүүд Нарангийн энгэр болон Цагаан даваанд баригдана

САНХҮҮЖИЛТ

30% өмчлөл, 70% зээлийн санхүүжүүлэлт
Төслийн нэгж ■



Эх сурвалж. Улаанбаатар хотынхөгжлийн корпораци

Мэргэжлийн хүний үг

Т.Чимэгсанаа: Паркуудын хөгжилд хувийн хэвшлийн манлайлал чухал

Ц.ЭЛБЭГСАЙХАН



Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын Чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркийн хэлтсийн дарга Т.Чимэгсанаатай Монгол Улсад үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төрийн бодлогын талаар ярилцлаа.

-Аж үйлдвэрийн яамтай болж, бодлогын баримт бичгийн талаас нэлээд зүйл тодорхой болж ирлээ. Үйлдвэр технологийн парк байгуулахад төрөөс ямар шийдвэр, тогтоол хэрэгжүүлж байна вэ?

-“Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл” 2003 онд гарсан, “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хууль 2009 онд батлагдсан. Энэ хоёр баримт бичгийг чиглэл болгон ажиллаж байгаа. Засгийн газраас одоогоор таван газар үйлдвэрлэл,

технологийн парк байгуулах зөвшөөрөл олгоод байна. Дархан, Эрдэнэт хот, Өмнөговь аймгийн Баян-Овоо, Завхан аймгийн Тэлмэн сумд болон хамгийн сүүлд өнгөрсөн тавдугаар сарын 23-ны хуралдаанаар Улаанбаатар хотын Багануур дүүрэгт үйлдвэрлэл технологийн паркийн зөвшөөрөл олгосон байгаа.

Парк байгуулж хөгжүүлэх үндсэн гурван чиглэл бий. Эхнийх нь “Тинант парк” гэж нэрлэдэг. Энэ нь гол төлөв өрхийн, жижиг дунд үйлдвэрлэлд түшиглэсэн жижиг парк. Хоёр дахь нь дагнасан парк буюу технологийн хувьд уялдаа бүхий нэг чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн нэгжүүдээс тогтдог. Гурав дахь нь холимог парк буюу технологийн хувьд уялдаагүй, олон чиглэлд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн нэгжүүдээс тогтдог. Манай өнөөгийн байгуулсан паркууд нь ерөнхийдөө холимог шинжтэй.

-Энэ газруудыг сонгосон шалтгаан нь юу вэ?

-Дэлхийн жишиг бий. Дээрээс нь УИХ-аас баталсан хууль тогтоомж, бодлогын чиглэлийн дагуу паркуудыг байгуулж байгаа. Хамгийн гол нь дэд бүтэцтэй байх ёстой. Бас түүхий эддээ ойр, ажиллах хүчний хүрэлцээтэй байх шаардлагатай. Мөн хөрөнгө оруулалт, тээвэр, газар зүйн байршлын хувьд оновчтой байх ёстой. Эрдэнэтийн хувьд гэхэд л хүнд үйлдвэрлэл хөгжсөн, дэд бүтэцтэй, түүхий эд нь тэндээ байгаа. Дархан гэхэд үйлдвэрлэлийн хот гэгддэг байлаа шүү дээ. Багануурын хувьд мөн “Багануур” ХК буюу нүүрсний уурхайг түшиглэж байгуулж байгаа. Дэд бүтэцтэй, ажиллах хүчтэй газар.

-Үйлдвэрлэх бүтээгдэхүүний хувьд ямар чиглэлтэй байх вэ?

-Эрдэнэтийн хувьд уул уурхайд

чиглэсэн хүнд үйлдвэрүүд түлхүүтэй. Холимог парк учраас хөнгөн үйлдвэр ч хамт хөгжино. Дарханы хувьд хүнд үйлдвэрийн, хөнгөн үйлдвэрийн, шинжилгээ судалгааны гэсэн гурван бүстэй, холимог парк. Ер нь парк гэдэг бол цогцолбор гэж ойлгох ёстой. Ямар цогцолбор вэ гэхээр олон талын хамааралтай, Засгийн газраас бодлогыг нь барьдаг, мэргэжлийн холбоод буюу үйлдвэрүүдийг төлөөлж үгээ хэлдэг байгууллага нь байх ёстой, мөн бүтээгдэхүүн гарахад нь шинжилгээ хийдэг лаборатори, гааль зэрэг мэргэжлийн байгууллагууд байдаг. Дээрээс нь үйлдвэрлэлээ дэмжсэн дэмжигч үйлдвэрүүд болон хамгийн чухал нь судалгаа шинжилгээний байгууллагууд байх ёстой. Ийм цогц хэлбэрээр хөгжиж байж цаашдаа парк тогтвортой ажилладаг юм билээ. Манайх ч энэ жишгийг баримталж байгаа.

-Сүүлийн үед төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг чухалчлах болсон. Паркуудыг хөгжүүлэхэд тэдний оролцоо ямар байх бол. Хувийн хэвшилд ямар боломж байгаа вэ?

-Олон улсын жишгийг харахад аж үйлдвэрийн паркийг хөгжүүлсэн гурван өөр туршлага байна. Нэгдүгээрт, стратегийн ач холбогдолтой төсөл гэж үзээд төр өөрөө бүх менежментийг нь хийж авч явдаг загвар бий. Эсвэл шууд хувийн хэвшил нь аж үйлдвэрийн паркаа байгуулаад хөгжүүлэлтээсээ ашгаа олоод явдаг. Үүнээс гадна ерөнхийдөө төр байгуулчихаад менежментийг нь хувийн хэвшилээр хийлгэдэг өөр нэг загвар байдаг. Манай орны хувьд гурав дахь загвар нь оновчтой гэж үзэж байгаа. Ер нь бол паркийн доторх бүтээн байгуулалтын бүх ажлыг хувийн хэвшил л хийх ёстой. Хувийн хэвшил ▶

▶ энэ үйлийг манлайлж, түүчээлж байж л паркууд хөгжинө. Төрийн зүгээс бодлогоо гаргалаа, дэд бүтэц бий болгох, хөрөнгө оруулалт татахад нь дэмжлэг үзүүлнэ. Түүнээс бусад бүх ажлыг хувийн хэвшил аваад явах ёстой.

-Парк байгуулах нь өөрөө их хөрөнгө, хүч шаардсан ажил гэж ойлгож байна. Үүнийг яаж шийдэж байгаа вэ?


-Дэд бүтэц бий болгоход асар хөрөнгө оруулалт шаардлагатай. Эрдэнэт, Дарханы хувьд бий болсон дэд бүтэц дээр тулгуурлаж байгуулах учир харьцангуй бага хөрөнгө оруулалт шаардлагатай. Багануурын хувьд ч бага. Гэхдээ хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Үүнийг улсын төсвөөс гаргахад хэцүү. Тиймээс төр хувийн хэвшлийн түншлэл буюу концессын хэлбэрээр шийднэ. Улаанбаатар хот бие даасан бодлогын хүрээнд Багануурын дэд бүтцийн зарим асуудлыг концесс руу оруулсан байна. Мөн гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт татах чиглэлээр тодорхой ажлууд хийнэ.

-Үйлдвэрлэл технологийн паркт орж ажилласнаар, паркийн нэг хэсэг болсноор аж ахуйн нэгжүүдэд ямар


татвар ногдох орлогоос хасаж тооцно. Хоёрдугаарт, паркийн үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн элэгдэл хорогдлын шинэтгэлийг хасч тооцно. Мөн машин тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг бууруулж гурван жилээр тооцдог. Гурав дахь нь парк

давхцал байдаг, газар чөлөөлөх асуудал гарч байгаа?

-Орон нутагт байгуулж байгаа паркуудыг орон нутгийн иргэдийн хурлаар шийдвэр нь гаргаж өгдөг. Түүний дагуу тухайн газрын албанаас давхцал байгаа эсэхийг тогтоодог. Ер



Хүнд үйлдвэр хөгжүүлэх боломжтой бүсүүд



Хөнгөн үйлдвэр хөгжүүлэх боломжтой бүсүүд

давуу талтай юм бэ?

-Яагаад парк байгуулах гээд байгаа гэхээр тэнд байгаа аж ахуйн нэгж тодорхой хөнгөлөлт урамшуулал сонирхож байгаа ш дээ. Дөрвөн төрлийн хөнгөлөлт үзүүлж байгаа. Нэгдүгээрт, паркийн дэд бүтцэд хөрөнгө оруулах юм бол тэр хөрөнгө оруулалтыг

баригдаад бүртгэгдсэн үл хөдлөх хөрөнгийг албан тагвараас чөлөөлдөг. Дөрөвдүгээрт паркийн газрыг газрын төлбөрөөс чөлөөлж байгаа.

-Паркийн газрын асуудлыг шийдэхэд ямар нэг бэршээл тулгардаг уу. Сүүлийн үед шинэ бүтээн байгуулалт хийе гэхээр газрын

нь манай паркуудын хувьд асуудалгүй. Орон нутаг бодлогынхоо хүрээнд хоосон байгаа орон зайдаа хийнэ.

-Үйлдвэрлэл, технологийн паркууд байгуулах ажил эхлэл түвшиндээ явж байна. Ямар нэгэн бэрхшээл тулгарч байна уу?

-Ер нь бол парк байгуулахад тодорхой хугацаа өнгөрч байна. Гэхдээ хуулийн хэрэгжилт нь тийм ч сайн биш байгаа. Энэ нь юутай холбоотой гэхээр юун түрүүнд нийгэмд аж үйлдвэрийн парк гэдэг ойлголт төлөвшөөгүй байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын бодлого оновчгүй явж ирсэн. Хууль эрх зүйн орчин нь мөн бүрхэг байна. Дээрээс нь паркт орё гэсэн аж ахуйн нэгжүүдийн технологийн түвшин хангалттай биш. Ийм шалтгаануудаас болоод ажлын явц удааширч байгаа.

-Парк байгуулахад судалгаа шинжилгээний байгууллагууд чухал үүрэгтэй гэсэн. Манай их сургуулиуд, шинжлэх ухааны хүрээлэн энэ ажилд хэр идэвх санаачлагатай оролцдог вэ?

-Шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулиудын эрдэмтэн профессорууд нэлээд сонирхож байгаа. Парк байгуулья, судалгаа хийе гэсэн хүсэлтүүд их ирдэг. ■

Бизнес

Төслийн санхүүжилтийг ахисан түвшинд гаргах нь

Б.ЭНХ

Тал дундаасаа барилгын ажил нь зогсчихсон “аргаг ясууд” Улаанбаатар хотын гудамжаар нэлээд олон. Тэдгээр барилгуудын цөөнгүй нь техник эдийн засгийн үндэслэл байхгүй төсөл дээр хөрөнгө оруулах шийдвэр гаргачихаад, мөнгө нь бүрэн шийдэгдээгүй байхад ажлаа эхлүүлж буруудаад, гагцхисан төслүүдэд багтана. Дампуурсан нь ч бий. Энэ бол төслийн санхүүжилтээ нэг мөр шийдээгүй байхдаа ажлаа эхлүүлсний харгай. Бизнес тэдний өндөр эрсдэлүүд байдаг ч төслийн санхүүжилтийн хувьд азаа үзнэ гэдэг үхлээ эрсэнтэй адил.

Төслийн санхүүжилт нь хөрөнгө оруулагч, зээлдэгч болон бусад талуудыг эдийн засгийн хувьд харилцан ашигтай, шударга байдлаар зардал, эрсдэл, үр ашгийн хүрээнд нэгдэхэд хүргэдэг хөрөнгө оруулалт юм. Энэ нь компанийн засаглалд өгөх анхаарлыг өндөржүүлдэг учир илүү ил тод, засаглал сайтай байхад ч хүргэдэг. Оюутолгой дээр олон улсын санхүүгийн байгууллагуудаас 4.4 тэрбум ам.долларыг босгож чадсан нь энэ төслийн хүрээнд хийгдсэн өмнөх ажлууд мөн бусад хүчин зүйлсийг үнэлж судалсны үр дүн. Өөрөөр хэлбэл, менежмент, хүдрийн чанар, дэд бүтэц, ирээдүйн боломжууд, Монгол Хятадын эдийн засаг гэх мэт олон талаас нарийн тооцоод, мөнгө зээллүүлээ. Энэ бол мега төсөл. Мега төслийн санхүүжилт төрийн хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дээр санхүүгийн институтуудээс зээл хөрөнгө босгож хэрэгжих бололцоо үүсдэг.

1990-ээд оны дундаас 2000-гаад оны эхэн хүртэл авсан хөрөнгийн дийлэнх буцалтгүй тусламж нэртэй, хариуцах эзэнгүй ч юм шиг байсан бол өнөөдрийн

монголчуудад хэрэг болж буй мөнгө тус бүр ардаа нэхэх эзэнтэй, тооцох хариуцлагатай. Тиймээс төслүүдийн ард зоож буй төсөв болгон эргээд төлөгдөх ёстой хүүтэй мөнгө л гэсэн үг. Үүний тод жишээ нь түүрүүчээсээ эргэн төлөлтөө нэхээд эхэлсэн Чингис, Самурай гэх мэт бондууд. Эдийн засаг өнгөжих тусам олон төсөл хөтөлбөрүүд гарч ирж, мөнгө эрэлхийлэх болов. Харамсалтай нь “Оюутолгой”, “Тавантолгой”, “Цагаан суварга”-ыг манай улсын банкууд ойрын хэдэн жилдээ



санхүүжүүлж дийлэхгүй. Мөн төр бонд гаргаж мөнгө босгочихоод нэг төсөлд хийх нь асар эрсдэлтэй алхам болно. Тиймээс л бондын мөнгийг янз бүрийн олон төсөлд тараан байршуулах замаар санхүүжилт хийсэн.

“Товчхондоо эрсдэлтэй салбарын том төслийг санхүүжүүлэх нэг арга нь төслийн санхүүжилт. Томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд тийм хэмжээний эрсдэл дагаж байгааг бизнесийнхэн мэддэг. Тиймээс үүнийг санхүүжүүлэх хэлбэр нь төслийн санхүүжилт. Үүнд олон компани оролцдог. Үүний жишээ нь Оюутолгой компанийн санхүүжилт” хэмээн эдийн засагч Ч.Отгочулуу хэлж байна.

Бидний хувьд төслийн санхүүжилт гэдэг нь шинэ ойлголт. Энэхүү

санхүүжилтийг дэлхийн томоохон байгууллагууд сүүлийн 60 жил хийж ирсэн байдаг. Жишээлбэл, Малайз, Солонгос зэрэг орныг хэлж болно. Тэд дэд бүтцээ хөгжүүлэхдээ төслийн санхүүжилтийг хэрэгжүүлсэн байдаг. Хэдийгээр манай улсын банкууд одоохондоо энэ санхүүжилтийг хийж чадахгүй ч цаашдаа хийдэг болох цаг үеийн шаардлага гарч ирж буй.

“Манай улсын банкуудын хувьд худалдаа, үйлчилгээ шууд олборлоод зардаг уул уурхайн хэсгийг санхүүжүүлдэг сурчихсан. Энэ нь илүү эрсдэл багатай. Одоо улс орны хэмжээнд шаардлагад байгаа илүү урт хугацаанд өгөөжөө өгдөг, арай илүү эрсдэлтэй төсөл, үйлдвэрлэл, дэд бүтцийн санхүүжилтийг олгож сурах хэрэгтэй” гэдгийг ХХБ-ны гүйцэтгэх захирал О.Орхон хэлж байсан.

Шинэ бизнесийг хөл дээр нь бат зогсох хүртэл хэрэг болох хөрөнгийг бага хүүтэй, барьцаа багатай авах нь манай нийгэмд ус агаар мэт шаардлагатай байгаа. Тэгвэл олон улсын байгууллагын, Засгийн газраас хэрэгжүүлдэг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах чиглэлийн төслийн зээлүүд ялангуяа гарааны бизнесүүдийг онилдог. Тэдний итгэлийг хүлээж, санхүүжилт авахын тулд хийдэг эхний алхам дээр манайх шиг хөгжиж буй орны бизнес эрхлэгчид хамгийн их алдаагийг мэргэжилтнүүд хэлж буй. Энэ бол төсөл бичих.

“Төслөө бичихдээ хөрөнгө оруулалтын үр ашгаа сайн танилцуулж чадаагүй, үндэслэл муутай, төсөлд хамааралгүй хүнээр бичүүлсэн зэргээс болоод хөрөнгө оруулагчдын гарт очихоороо гологдох хандлагатай байдаг. Тиймээс энэ тал дээр сургалт авч, мэдлэгээ сайжруулах хэрэгтэй” гэдгийг МҮХАТ-ын Жижиг, дунд үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих газрын дарга Н.Долгормаа хэлсэн юм.

Төсөлд бизнесийн гадаад, дотоод орчны судалгаа, хэрхэн өргөжүүлэх төлөвлөгөө, хэрэгцээт бараа, материал, тоног төхөөрөмжийн тооцоолол зэрэг шаардлагатай бүх мэдээлээс гадна хүсч буй мөнгөн дүн ч тодорхой байх ёстой. Төслөө аливаа санхүүжүүлэгч байгууллагад өргөн бариад зээл авч чадсан ч шаардлагатай бүх санхүүжилтээ тусгаж чадаагүйгээс бизнесүүд хүссэн ▶

▶ хэмжээндээ өсч чадахгүй байх тохиолдол байдаг аж. Энэ бол жижиг, дунд үйлдвэрлэл буюу гарааны бизнесийнхний гаргадаг нийтлэг алдаа. Зөвхөн эргэлтийн хөрөнгөөр санхүүжилтээ тооцох нь алдаа юм. Тиймээс эргэлтийн хөрөнгөөс гадна зээлээ эргэн төлөх, эрсдэлийг удирдах, даван туулах, техник төхөөрөмж худалдан авах, түүний засвар үйлчилгээ гээд маш олон зүйл төсөлд багтаж байх хэрэгтэй.

“Компаниуд төсөлдөө санхүүжилт татахын тулд засаглалаа сайжруулан, ТЭЗҮ болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө зөв баталж сурах зайлшгүй шаардлага бий. Түүнчлэн дэлхийн хаана ч очсон, томоохон банк санхүүгийн байгууллагын удирдлагуудтай уулзахдаа тэдний түвшинд хүрч харилцах чадвартай боловсон хүчинтэй болох учиртай” хэмээн эдийн засагч Ч.Отгочулуу хэлсэн.

Жижиг том гэлтгүй ямар ч төсөл үр ашигтай эсэхийг тооцож үзсэнийхээ дараа өөрөөр хэлбэл, яг ямар аргаар санхүүжүүлэх вэ, үндсэн хөрөнгө мөн зээл хэд байх вэ гэх мэт бүгдийг тооцож, эргээд төслөөс гарах мөнгөн урсгалтай нь уяж үзээд, ийм хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай гээд санхүүжүүлэгч байгууллагуудад хандахыг мэргэжилтнүүд зөвлөж байна. Энэ үйл явцыг шат дараатай бүрэн гүйцэтгээгүй процессийн алдаа гаргасан төслүүд өдгөө гашуун туршлага болчихоод буй. Хэрвээ том төслийн хүрээнд ярьж байгаа бол бүх санхүүжилтийг зөвхөн нэг банк, байгууллага өгөхгүй байх нь бий. Санхүүжүүлэгчид мөнгө нь байлаа ч бүх санхүүжилтийг дан өөрөөсөө гаргаж том эрсдэл үүрэхгүйгээр бусадтай хамтарч эрсдэлээ хуваах жишиг өргөн мөрдөгддөг. Төсөл хэрэгжүүлэгчийн хувьд нийт санхүүжилтээ нэгмөсөн тохирсоны дараа ажлаа эхлэх нь зүйтэй гэдэг.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханы хэлж байгаагаар бол 100 төгрөг хэрэгтэйгээс 90 төгрөг нь ороод ирчихсэн ч сүүлийн 10 нь байхгүй бол ажлаа эхлэлтгүй. Энэ бол зарчмын том асуудал. Хөрөнгө мөнгөө нэг мөр шийдээд тэгээд төслийн барилгын явцыг тасралтгүй явуулах нь бизнесийн хувьд байнгын үр ашигтай байхад хөтөлнө. Хэрвээ дундаа хөрөнгө тасарчихвал зардал л нэмэгддэг гэж зөвлөсөн.

Бид сүүлийн жилүүдэд төсөл гэдэг үгийг өргөн дэлгэр ашиглаж сурлаа. Олон төслийн санааг ч гаргаж үзлээ. Төсөл бичиж үзсэн гэх тааралдсан нэгнээрээ төсөл бичүүлсэн болоод хүний урдаас шидчихдэг үе өнгөрсөн. Иймэрхүү төслүүдийг буцалтгүй тусламжийнхан л тоодог байсан байх. Одоо гадаад дотоодын хөрөнгө оруулагч байгууллага, хүмүүст тоогдохын тулд итгэл үнэмшил, үндэслэл сайтай, ирээдүйтэй төслүүд гаргаж ирж, амжилттай хэрэгжүүлж сурах хэрэгтэй байна. Учир нь тэд бидэнд туслах гээгүй, харин ашиг олох сонирхлоор бидэнтэй зам нийлэх эсэхээ шийддэг улс. ■

Mongolian Economy сэтгүүлийн асуулт:

-Улаанбаатар хотод аж үйлдвэрийн паркууд байгуулах нь эдийн засаг, бизнест хэрхэн нөлөөлөх вэ?

Ч.Хашчулуун /МУИС-ийн доктор, эдийн засагч, Хувийн хэвшлийг дэмжих үндэсний зөвлөлийн Ерөнхийлөгч/



-Улаанбаатар хот бол Монгол Улсын эдийн засгийн үлэмж хувийг эзэлдэг, маш их төвлөрөл бий болсон том төв. Өдийг хүртэл Улаанбаатар хотод олон үйлдвэр ажиллаж байсан. Бүхэл бүтэн хороолол хүртэл “үйлдвэрийн район” нэртэй байлаа. Орчин үед дэд бүтэц, тээвэр, шинэ технологи хэрэгтэй болж байна. Ажиллах хүч, цахилгаан, ус, ялгаруулж буй агаар хөрсний бохирдлын гээд асуудал тулгарч байгаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас эдгээрийг шийдэхийн тулд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслүүд гаргаж байгаа нь цаг үеийн шаардлагатай уялдаж байгаа юм. Өнөөдөр Улаанбаатар хотын өмнөд хэсэг, үйлдвэрийн гудамж, Гурвалжингийн гүүр орчмоор үйлдвэрүүд төвлөрсөн ч нэг сая гаруй хүн амтай хотын эрүүл ахуй, орчин нөхцөл гээд олон талаар шаардлага хангахгүй байна. Одоогоор Багануур дүүрэгт аж үйлдвэрийн парк байгуулах зөвшөөрөл гарсан. Налайх, Багануур дүүргийн хувьд нэг давуу тал нь тэнд дэд бүтэц бий. Хамгийн гол нь ажиллах хүчин хангалттай. Уурхайгаа түшиглэж олон жил болж байгаа учир мэргэжилтнүүд элбэг, үйлдвэрлэлийн технологийн парк байгуулж хөгжих туйлын бололцоотой.

Д.Байлхүү /Төрийн өмчийн хорооны зөвлөх, Компанийн сайн засаглалын төвийн Удирдах зөвлөлийн гишүүн/



-УИХ-аас үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хуулийг 2009 онд гаргасан. Ер нь манай улсад хуулиар хориглоогүй ямар ч үйлдвэрлэл аж ахуйн газрыг хуулийн этгээд дурын бололцоотой газарт байгуулж болно. Гэтэл зориуд ийм хууль гаргаж байгаа шалтгаан нь үйлдвэр аж ахуйн газрыг ганц нэгээр тодорхой нэгдсэн бодлоггүй барьж байгуулж байгаа өнөөгийн байдлыг өөрчлөх, тодорхой нутаг дэвсгэрт, тодорхой төрлийн хоорондоо уялдаа бүхий үйлдвэр, үйлчилгээг цогцоор нь тогтоосон төлөвлөлтийн дагуу байгуулахыг төрөөс бодлого болгож байгаагаар нийтэд зарлаж түүнийг нь хэрэгжүүлж байгаа этгээдэд үзүүлэх төрийн дэмжлэгээ хуульчлан өгч байгаа явдал юм. Төрөөс гаргасан энэхүү бодлогыг нийслэл Улаанбаатар хот өөрийн хөгжлийн бодлогын хүрээнд ашиглах зорилгоор хэд хэдэн төрлийн хоорондоо уялдаа бүхий үйлдвэр, үйлчилгээний төв буюу парк байгуулахаар шийдвэрлэсэн. Тухайлбал, Эмээлтэд хөнгөн үйлдвэрлэлийн, Налайхад барилгын материалын, Баянзүрх дүүргийн зүүн хэсэгт барилгын материалын худалдааны, Налайхын баруун урьд хэсэгт ложистикийн төв зэргийг байгуулахаар шийдвэрлэсэн. Ингэснээр Улаанбаатар хот доторх хөнгөн болон барилгын материалын үйлдвэр, худалдааны ажиллагаа мөн хотын ▶

▶ доторх төмөр зам дагасан ачаа, бараа ачих, буулгах, хадгалах олон байгууламж хотоос гадна төвлөрнө. Энэ нь нийслэлийн хөгжил, хөдөлгөөнийг өнөөгийн шаардлагад нийцүүлэхэд томоохон өөрчлөлт болохоос гадна бизнес эрхлэгчдэд шаардлагатай орчныг бүрдүүлсэн зориулалтын газар олон төрлийн хөнгөлөлттэй нөхцөлд үйл ажиллагаа явуулах бололцоо гарах зэрэг олон талын ач холбогдолтой.

Өнөөдрийг хүртэл эдгээр цогцолборын байршлыг тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай зураг төслийг боловсруулах, байгаль орчны судалгаа хийх, дэд бүтцийн асуудлыг тодорхой болгох чиглэлээр нэлээд ажил хийсэн. Энэ форум нь хийсэн ажлуудаа нийт сонирхогч талуудад танилцуулж, цаашид хамтран ажиллах боломжийг олгож байна.



Д.Хулан /Natural Essentials компанийн Гүйцэтгэх захирал/

-Миний хувьд үйлдвэрлэлээ хөгжүүлэх, өргөжүүлэх сонирхлоор хоёр жилийн турш үйлдвэр барих газар хайж байна. Улаанбаатар хотод бүх газар нь эзэнтэй болчихсон юм байна. Эзэд нь тэр газраа юунд ч ашигладаггүй мөртлөө байлгаад л байх сонирхолтой. Тиймээс төр засгийн зүгээс бодлогоор парк байгуулаад үнэхээр зохих ёстой аж ахуйн нэгжид нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, газрыг олговол сайхан л байна. Тэгэхдээ аль болох байгальд ээлтэй үйлдвэрлэлийг илүү дэмжиж, давуу байдал олгох нь зөв болов уу. Харамсалтай нь аж үйлдвэрийн парк байгуулах тухай асуудал их удаан яригдаж байгаа ч ахиц гарахгүй байгаа. Тиймээс үйлдвэрлэгчдэд бодитой боломж бий болох уу, үгүй юу гэдэгт итгэл дундуур л байна.



И.Сэр-Од /“Mongolian Business Database” ТББ-ын тэргүүн/

-Ер нь дэд бүтэцгүй, зам харилцаагүй алслагдмал газар парк байгуулчихаад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг тийш нь татахад төвөгтэй. Тэр талаасаа Улаанбаатарт аж үйлдвэрийн парк байгуулах нь олон давуу талтай юм. Бизнес кластер хэрэгтэй гэж сүүлийн хэдэн жил шат шатанд ярьсан. Дэд бүтэц нь бий болчихсон, тээвэр нь тогтчихсон, зах зээл нь тодорхой, бараагаа түгээх сүлжээ нь бий болсон цогц системийг бүрдүүлэхэд нийслэл хамгийн тохиромжтой нь. Алслагдсан аймгуудын худалдаачид хүртэл Улаанбаатараас л бөөний бараагаа татаж байна шүү дээ. Нэгэнт бий болчихсон энэ давуу талаа ашиглах хэрэгтэй. Гэхдээ нэг талаас төвлөрлийг сааруулах, багасгах бодлого барих нь зөв болохоор паркуудыг хот дотор бус дагуул хот болгон хөгжүүлэх байдлаар шийдэх ёстой байх. Хоёрдугаарт, экологийн асуудлыг их зөв тооцоотой хандаж, орчин үеийн байгальд ээлтэй технологи ашиглах, үйлдвэрлэлээс ялгардаг их хэмжээний хаягдал, бохир усыг оновчтой зохион байгуулах гээд систем, механизм нь тодорхой бол нийгэм, эдийн засагт олон эерэг үр дагавар авч ирнэ. Өнөөдөр хотын төвд байгаа арьс ширний үйлдвэрүүдийг хотоос гаргах зэрэг аж үйлдвэрийн парк байгуулах цаг үеийн шаардлага бий.

Ярилцлага

Сонирхол татахын тулд хүчтэй дэд бүтэцтэй байх хэрэгтэй



Б.ЭНХЦЭЦЭГ

Европын сэргээн босголт хөгжлийн банк /ЕСБХБ/-ны Монгол дахь суурин төлөөлөгч Мэтью Д. Лэ Блантай бид уулзаж, тус банкны үйл ажиллагаа тэр дундаа Улаанбаатар хоттой холбоотой хийгдэхээр төлөвлөж буй ажлуудыг сонирхлоо. Мэтью нь хөгжлийг санхүүжүүлэх чиглэлээр 15 жил ажилласан бөгөөд ЕСБХБ-д 2001 онд дэд бүтцийн шинжээчээр ажилд орж байжээ. Тэрбээр үүнээс хойш Гүрж, Тажикистан, Турк зэрэг орнуудад ажиллаж дэд бүтцийн олон гэрээ хийн, том жижиг төслүүдэд санхүүжилт олгожээ. Тэрбээр 2013 оноос хойш Монголд суурин төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна.

-ЕСБХБ-ны Монгол дахь үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар товчхон мэдээлэл өгөхгүй юү ?

-Бид 10 жилийн өмнө Монголд суурин төлөөлөгчийн газраа нээж байсан. Түүнээс хойш төслүүдэд нийт 1.5 тэрбум ам.долларын санхүүжилт хийсэн бөгөөд үүний зэрэгцээ ▶

▶ хамтын санхүүжилтэд 2.5 тэрбум ам.долларыг хөдөлгөсөн байдаг. Энэхүү санхүүжилтийн гуравны хоёр уул уурхайд ногдож буй. Үүний нэлээд том хэсэг нь Оюутолгой. Бид саяхан 1.2 тэрбум ам.долларын санхүүжилтийг Оюутолгойд зохицуулж өгснөөс 400 сая ам.долларыг ЕСБХБ-аас шууд гаргасан.

Сонирхолтой нь төслүүдийн гуравны хоёр нь уул уурхайн бус салбарт хамаарч буй нь эдийн засгийн төрөлжилтийг дэмжих зорилготой нийцэж буй. Төрөлжилт гэхээр бидний бодолд ихэнхдээ жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил орж ирдэг. Энэ нь ч ажлын байр бий болгодог хүчтэй оролцогчид бөгөөд Улаанбаатараас гадна бүсүүдэд чухал нөлөөлөлтэй. Бид бүсийн хөгжилд мөн чухал ач холбогдол өгдөг. Уул уурхайн бус салбарт манайх ХААН, ХАС гэх мэт дотоодын арилжааны банкуудыг санхүүжүүлэх замаар оролцдог. Мөн дотоодын жижиг бизнесүүдийг дэмжих зорилгоор эрчим хүчний үр ашигтай зарцуулалтыг дэмжих зээл, ЖДҮ зээл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн зээл гэх мэт тусгай хэрэгслүүдийг хөгжүүлсэн. Мөн шууд шугамаар ЖДҮ-ийг бид санхүүжүүлж байсан нь ч бий. Бид юу санхүүжүүлдэг вэ гэвэл ерөнхийдөө импортыг орлох үйлдвэрлэл. Монгол маш ихийг импортлодог. Үүнийг бид 2011-2012 оны тэсрэлтэт үед импорт огцом өсч, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахад тод харсан. Олон бүтээгдэхүүнийг Монголд үйлдвэрлэж болно гэдэгт итгэдэг. Үүнийг бид наад зах нь ус, ундаа, шар айраг цаашлаад барилгын материалаас харж болно. Тухайлбал, “Монполимет” компанийн цементийн үйлдвэрийг санхүүжүүлсэн. Хэрэв өндөр чанарын цементийг Монголдоо үйлдвэрлэвэл, энэ нь үл хөдлөхийн салбар мөн хоёрдугаар шатны бүтээн байгуулалтад цементний асар их хэрэгцээ гарах Оюутолгойд сайнаар нөлөөлнө. Энэ бол бидний алсын хараа.

Мөн бид Монголд зөвхөн импорт орлох бүтээгдэхүүнээр зогсохгүй өөр олон сонирхолтой төсөл дээр ажилладаг. Жишээ нь, “Орчлон” сургууль, “Интермэд” эмнэлгийг санхүүжүүлсэн. Төсвийн хувьд асар их дарамтад байгаа энэ үед боловсрол, эрүүл мэндийн салбарт ийм хоёр санаачлага гарч ирсэнээрээ сонирхолтой. Энэ бол чухал үзүүлэлт учраас санхүүжүүлсэн. Харин Салхитын станцаас өөр дэд бүтцийн төслийг төдийлэн санхүүжүүлж амжаагүй байна.

Энэ бол дэд бүтцийн салбар дахь PPP буюу төр хувийн хэвшлийн зарчмаар бий болсон анхны бүтээн байгуулалт. Энэ салбар дахь жинхэнэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт.

-Одоогийн эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор танай банкны хувьд төслийн санхүүжилтэд хандах хандлагаа өөрчлөх шаардлага гарч байна уу. Эргэн төлөлтийн хувьд тааруухан байгаа зээл бий юу?

-Бид эрсдэлтэй нүүр тулгарсан. Тодруулаад хэлэхэд энэ л институцийн сайхан нь юм. Манайх олон улсын арилжааны банкуудын дааж чадахгүй эрсдэлийг өөр дээрээ авдаг. Энэ бол бидний хувьд тооцоолсон эрсдэл. Уул уурхайн салбарт зах зээл эргэж, тавааруудын ханш тааруу болсноос үүдэн бид зарим хүндрэлүүдтэй нүүр тулгарч байгаа.

-Уул уурхайн салбарт нэлээд их мөнгө алдаж байгаа гэсэн үг үү?

-Үгүй, хэд хэдэн төслүүдийн хувьд дахин өрийн бүтцэд нь өөрчлөлт хийх талаар яригдаж байгаа гэсэн үг. Үйлчлүүлэгчид илүү амьсгаа авах хугацаа хэрэгтэй байгаа бол бид түүнийг нь тодорхой нөхцлүүд тухайлбал өрийн бүтцийн өөрчлөлт итгэл даахуйц байх мөн ирээдүйн бэлэн мөнгөний урсгал баталгаатай байх гэх мэт нөхцлүүдийг нь хараад өгөх сонирхолтой байдаг. Бид эргэн төлөлтийг зүгээр нэг хойшлуулах гэж бүтцэд өөрчлөлт хийдэггүй. Компанийг аварч, ирээдүйд илүү хүчирхэг компани болгох зорилгын төлөө бид нэгдэж байгаа.

-Танай банкиг Улаанбаатар хотын хөгжлийн корпорацитай /УБХК/ хамтарч ажиллахаар зэхэж буй гэсэн сураг бий. Тэгвэл хэрхэн хамтрахаар төлөвлөж байгаа вэ?

-Бид тэдэнтэй хамтрах хүсэлтэй байгаа. УБХК бол төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх сайн туршлага, сайн талбар болно гэдэгт итгэж буй. Зарим санхүүжилтийн суурийг бий болгох хэд, хэдэн хөрөнгүүд УБХК-т очсон ч бид тэднийг Улаанбаатар хотын төвөгтэй дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх чадвартай мэргэжилтнүүдийн баг гэж харж буй. Тэдэнд гэрэлтүүлэг, автомашины зогсоол гэх мэт төслүүд бий. Тэд бүгд PPP-ийн замаар шийдэгдэх ёстой. Энэ нь тийм амар биш ч санхүүжилт, тухайн хөрөнгүүдийг удирдах үйл ажиллагаанд ч тэр хамаагүй үр ашигтай хувилбар юм. Азийн хөгжлийн банкны зүгээс мөн



мэргэжлийн суурь баазыг бий болгоход тодорхой хэмжээний дэмжлэгүүдийг үзүүлэхээр зорьж буй, заримыг нь өгөөд эхэлсэн байгаа. Харин бидний зүгээс дэд-төслүүдийг санхүүжүүлэх талаар ярилцаж байна. Энд л бидний байр суурь байна гэж харж байгаа.

-Яг ямар төслүүдийн тухай бид яриад байна вэ?

-Бидний хувьд метро тэргүүтэй нүсэр төслүүдийн хувьд нэлээд болгоомжтой хандаж буй. Хэдэн тэрбум ам.долларын санхүүжилтийн тухай өнөөдөр ярих нь тохиромжтой гэж бодохгүй байгаа. Хэн нэгэн санхүүжүүлэх хүсэлтэй бол сайн л байна. Гэхдээ хувийн хэвшлийн үндсэн дээр үүнийг хийнэ гэдэг хэцүү л байх болов уу. Бидний хувьд илүү УБХК-ийн хувьд PPP шугамаар хэрэгжүүлэх жижиг төслүүд дээр анхаарлаа хандуулж байгаа. Тээвэр, ус, гэрэлтүүлэг, бохир ус зэрэг хотын асуудлыг хамарсан жижиг төслүүд байж болно гэж харж байна.

Өнөөдөр Монголд, үнэ тарифийн асуудал байсаар байна. Үнэ тарифаар зардлаа нөхөж чадахгүй л юм бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах хэцүү байсаар байна. Бид улс төрийн хувьд эмзэг асуудал гэдгийг нь ойлгож байна. Гэхдээ үнэ тарифийн дарамтыг хөнгөлөх олон арга бий шүү дээ. Түүний нэг нь алдагдлыг бууруулах. Мөн үүний зэрэгцээ үр ашигтай компаниудтай болох боломж байна. Өнөөдөр хотын нийтийн үйлчилгээ үзүүлэгч олон газар ▶



► хүндрэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зөвхөн засвар хийх байдлаар явж ирлээ. Хэрвээ хөрөнгө оруулалт хийж, сайн чанартай тоног төхөөрөмжтэй болвол илүү үр ашигтай ажиллах тал дээр анхаарах орон зай үүснэ. Бидний хувьд хотын дэд бүтцийг хөгжүүлэхэд суурь ач холбогдолтой гэж үзэж буй хүчин зүйл нь цахилгааны үнэ тарифыг өсгөх гэж үзэж байгаа. Монголчуудын хувьд цахилгаан, дулаан зэрэг үйлчилгээ авсан төлбөрөө төлөхдөө хойрго ханддаггүй нь маш сайн хэрэг. Миний ажиллаж байсан хэд, хэдэн улсад үйлчилгээ их муу байсан учир иргэд нь төлбөрөө төлөхдөө ихээхэн дурамжхан байдаг байлаа. Эндхийн үйлчилгээг бол би муу гэж хэлэхгүй харин ч одоогийн хамаг юм нь хуучирчихсан нөхцөлд буй компаниудын хувьд ийм хэмжээний чанартай үйлчилгээ үзүүлж чадаад байгаад нь би гайхдаг. Жаахан хөрөнгө оруулалт тэгээд хүчтэй менежмент байхад л тэдгээр компаниудын зардлын дарамтыг хөнгөлж, үр ашигтай болгож чадна. Улаанбаатар хөгжлийн корпорацийн хувьд жижиг төслүүдээс эхэлж барьж авч, “know-how”-аа бий болгоод улмаар илүү нарийн төвөгтэй төслүүд рүү орох нь зүйтэй болов уу гэж бодож байна. PPP нарийн төвөгтэй зүйл. Гэхдээ үүний сайхан нь хувийн хэвшилд ихээхэн хариуцлагаа үүрүүлдэг нь юм. PPP-тэй байхад та өөрөөсөө компанийг хэрхэн удирдах вэ гэж асуудаггүй.

Учир нь хувийн хэвшил үүнийг хийдэг. Сонгогдсон компаниуд илүү их хариуцлага үүрч, үр дүн, үнэ тарифаа хариуцна. Дэд бүтцийг хурдан хугацаанд сайжруулах хэрэгтэй байна. Дэд бүтцийн төсөлд нэлээд урт хугацаа ордог. Эдийн засаг, хүн амын өсөлтийн хурдтайгаа зэрэгцэж явья гэвэл Улаанбаатар гэс өөр хог болох хэрэг гарч байна. Тийм ч учраас бид УБХК-ийг тэдгээр төслүүдийг хэрэгжүүлж чадна гэж бодож байгаа. Гэхдээ хугацаа хэрэгтэй.

-Танай банкны хувьд иймэрхүү бүтээгдэхүүн шууд утгаараа үйлдвэрлэлд гаргаад зардаггүй дэд бүтцийн салбараас яаж ашиг олддог юм бэ?

-PPP бол тийм өндөр ашигтай хувилбар биш ч гэсэн тогтвортой мөнгөн урсгалыг бий болгож байдаг. Тиймээс Франц, Туркт иймэрхүү төслүүдийг хэрэгжүүлэх сонирхол өндөртэй хувийн хэвшлийн аварга компаниуд байдаг. Хэдийгээр ийм төслүүд хөрөнгө их шаарддаг ч урт хугацаанд мөнгөн урсгалыг бий болгодог бөгөөд мөн PPP-ийн хамрах хүрээ, гэрээгээр баталгаажуулж байдаг. Үнэ тарифыг урьдчилж тааварлахад бүрэн боломжтой учир үйл ажиллагааг хариуцагч нь л сайн байвал эрсдэл багатай байдаг. PPP бол аль ч талдаа ялалт авчирдаг хувилбар. Бидний хувьд гарз хохирлоо багасгах ёстой болохоос ашгийн хойноос явах нь гол зорилго биш. ЕСБХБ-ны үүрэг бол төвлөрсөн эдийн

засгаас зах зээлийн эдийн засаг руу орох шилжилтийг дэмжих байсан. PPP бол үүний нэг хэсэг. Хэдий сорилт бий ч бидний хувьд үүнийг санхүүжилт болон технологийн шийдлийн зүгээс харвал хотын тогтвортой дэд бүтцийн хөгжлийг хангах хамгийн шалгарсан арга гэдэгт итгэдэг. Энэ бол төслийн санхүүжилт. Тэдгээр төслүүд мөнгөний урсгал дээр тогтдог. Хэдэн тэрбум ам.доллараар нь мөнгө олоод байхгүй ч тогтвортой, тооцоолж болохуйц мөнгөний урсгал ийм төслүүдийг дагадаг. Тийм учраас бид тодорхой үнэ тарифын бодлоготой л бол PPP-г хотын дэд бүтцийн хөгжлийг хангахад тохирох сайн бүтэц гэж бодож байна.

-Аж үйлдвэр, технологийн парк Монголд байгуулах талаар та юу гэж бодож байна вэ?

-Бид энэ тал дээр нэг бус хувилбарыг харж байлаа. Хэдэн шалтгааны үүднээс аж үйлдвэр технологийн парктэй байх нь ач холбогдолтой байдаг. Эхнийх нь ложистик. Дараагийн нь дэд бүтэц. Нэг цэгт төвлөрсөн түүхий эдийн тээвэрлэлт мөн хотыг чиглэсэн сайн зохион байгуулалттай тээвэрлэлтийн тогтолцоотой бол зардлыг бууруулж чадна. Бид Монголд хувийн хэвшлийнхний нүүр тулдаг хамгийн том сорилтуудыг судалж үзэхэд цахилгаан эрчим хүчний хүртээмж багтаж байсан. Цахилгаан эрчим хүчинд холбогдоход нэлээд хугацаа, зөвшөөрөл гэх мэт бусад зүйлс шаардагддаг. Нэг их цахилгааны хязгаарлалт, тасалдал тохиолдоод байдаггүй улсын хувьд энэ их сонин хэрэг ч бодиг байдал ийм байгааг зааж байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр хэрвээ танай компани эрчим хүч, цэвэр, бохир ус, тээвэрлэлтийн системд шууд холболттой бол мэдээж хэрэг илүү үр ашигтай ажиллана. Энэ талаас нь харвал бидэнд аж үйлдвэрийн парк гэх санаа таалагдаж байгаа. Үр өгөөжийг нь олж хараад, энэхүү паркын үйл ажиллагаанд орохыг сонирхож буй компаниуд хотод бий. Бид энэ төслийг харж байгаа. Гэхдээ аж үйлдвэрийн паркын дэд бүтцийн санхүүжилтийн талаар бодолцож үзэхэд хэтэрхий эрт байна. Хэрвээ аж үйлдвэрийн парк гэхээр зүгээр л нэг хэсэг газар байх юм бол энэ хол явахгүй. Сонирхол татам байхын тулд хүчтэй дэд бүтэцтэй байх хэрэгтэй. Байршил чухал хэдий ч гол хүчин зүйл биш. Хэрвээ чанартай, олон төрлийн боломжийг нэг дор авчирсан төвлөрсөн үйлчилгээг санал болговол компаниуд таагдана. ■

Гаднын туршлага

Дэлхийн аж үйлдвэрийн сонин хачин

Орчуулсан Б.ТУЯА

Аж үйлдвэр Америкийн эдийн засгийг хөдөлгөхөө больсон байж болох ч тус улсын олон хэсэгт эл салбарын өсөлт хүчтэй хүчин зүйл хэвээр байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллах хүчин өнгөрсөн таван жилийн хугацаанд 7.5 хувиар өссөнөөр 855 мянган ажлын байр шинээр бий болжээ.

Энэхүү хандлагын эрчимт хөдөлгөөнд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг нь Хятадын ажлын хөлс өссөнтэй холбоотой төдийгүй эрчим хүчний салбарт тохиосон өсөлт болон хэрэглэгчийн эрэлтэд хариу үйлдвэл хурдан үзүүлэх шаардлага улам нэмэгдэж, зах зээл хувьсан өөрчлөгдөж байгаатай нягт холбоотой ажээ. АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн хороонд байх мэдээлэлд үндэслэн нэгэн сонирхолтой тооцоолол гаргасныг Forbes танилцуулсан байгаа юм. Үүнд сүүлийн 10 гаруй жилийн турш цуглуулсан 373 метрополитан хотын статистикийг гаргахдаа урт хугацааны (2003-2014 он), дунд хугацааны (2009-2014) болон сүүлийн хоёр жил төдийгүй өнөөгийн байдалд аж үйлдвэрийн салбарын ажлын байран дахь үзүүлэлтүүдийг жагсаасан байгаа юм.

Зэвэрсэн бүс эргэн иржээ

Хэдийгээр сүүлийн 40 жилд АНУ-ын томоохон хотуудад аж үйлдвэржилт зогсонги байдалд орсон гэж болох ч саяхнаас автомашины үйлдвэрлэлд хурдацтай өсөлт ажиглагдах болсон нь аж үйлдвэрийн бүсүүдийн эдийн засагт сэргэлт авчирч байна. Автомашины худалдааны оргил үе өнгөрсөн гэх яриа гарч буй ч өнгөрсөн зургаан жилийн турш тус төрлийн худалдаа өсөлттэй гарсаар байгаа нь хүүгийн бага хүү, хэрэглэгчид хуучин машинаа шинээр солих сонирхол нэмэгдэж байгаатай холбоотой аж.

Энэ өсөлтийн гол цэг нь уналт эхэлсэн газраас эхтэй гэдгийг Forbes өгүүлжээ. Тухайлбал, аж үйлдвэрийн салбар дахь ажлын байрыг хамгийн ихээр бүрдүүлэгч Мичиган муж эдийн засгийн хямралын үеэр алдаад байсан ажлын байрныхаа 40 хувийг эргүүлэн сэргээж чадсан байгаа юм. Тэгвэл тус салбар дахь ажлын байраараа

тэргүүлдэг Детройт-Дийборн-Ливониа хотуудад аж үйлдвэрийн ажлын байраар тэргүүлэгч болсон талаарх судалгаа байгаа юм. 2009 оноос хойш уг бүсийн аж үйлдвэрийн салбарын аж үйлдвэрийн салбар 31.3 хувиар өссөн бол 2014 онд 9.8 хувар ахисан байгаа юм. Энэ нь нийтдээ 90 мянган орчим ажлын байр шинээр нэмэгдсэн гэсэн үг аж. Гэсэн ч ▶



► 2003 оны үзүүлэлтээд 12.3 хувиар бага үзүүлэлт юм байна. Гэвч санхүүгийн хямрал тохиосон 2009 оны тоон дүнгээс 5.9 хувиар нэмэгдсэн индекс аж.

Өмнөд хэсэг буцалж байна

АНУ-ын өмнөд хэсэгт асар аж үйлдвэрийн асар том кластер “буцалж” байна. Учир нь тус бүсэд Герман, Япон тэргүүтэй хөрөнгө оруулагчид томоохон төслүүд хэрэгжүүлж эхэлжээ. Үүний нэг тод жишээ бол Нашвиль-Давидсон –Мурфрийсборо (Теннисий муж) дахь аж үйлдвэрийн ажлын байр 2009 оноос хойш 23.9 хувиар үсэрчээ. Японы Nissan болон Bridgestone Теннисий мужийн төвд өөрийн үйлдвэрээ байгуулаад авсан гэдгийг дуулахад илүүдэхгүй биз. Түүнчлэн Nissan өөрийн төв

оффисоо Өмнөд Каролина мужуус тус нутагт шилжүүлсэн.

Газрын тос, байгалийн хийн ханш уруудсаар байна. Улмаар хайгуул төдийгүй өрөмдлөгийн төсөв хумигдаж буй. Энэ нь аж үйлдвэрийн салбарт хүчтэй нөлөөлөх болсон.

Тэгвэл Их Британийн хувьд аялал жуулчлал хийгээд аж үйлдвэрийн эрэлт ихтэй газруудыг тодруулсан байна. Их Британийн Үндэсний аялал жуулчлалын агентлаг нэгэн сонирхолтой судалгаа гаргасан байна. Үүнд 2011 оноос хойш ирсэн гийчид хааш зорьсныг харуулсан байна. Манчестер хотыг зорих хүмүүсийн дийлэнх нь хөл бөмбөгийн фанатууд байдаг ч Дитройт хотын адилаар нэг хүнд ногдох инженерийн суралцах хүмүүсийн тоо өсч байгаа нь салбар сэргэж буйн илрэл хэмээж

байна. Түүнчлэн хамгийн сүүлд 2011 онд гарсан бүрэн судалгаагаар Их Британийг зорих жуулчид тус улсын хамгийн том аж үйлдвэрийн хотуудыг зорих болсон гэдгийг тус улсын үндэсний аялал жуулчлалын агентлаг мэдээлжээ.

Эдгээр хотод Бермингхам, Ливерпүүл, Гласгов багтаж буй ажээ.

Дэлхийн хоёр дахь том эдийн засаг Хятадыг “Дэлхийн үйлдвэр” гэж зүгээр ч нэг хочлоогүй. Тухайлбал Тианжин тус улсын томоохон боомт хотуудын нэг төдийгүй үйлдвэрлэлийн уурхай нь юм. Хэдийгээр чингэлэгийн долоо дахь том боомт хот боловч жилд 10 сая чингэлэг ачдаг байна. Түүнчлэн 179 төрлийн аж үйлдвэрийн парктэй бөгөөд эдгээр нь агаарын тээвэр, детрохими, автомашин, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон материал үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө гэх мэт өргөн хүрээ хамардаг. Эдгээрийн 19 нь таван ам километр газар эзэлдэг аж. ТОмоохон гэгддэг есөн аж үйлдвэрийн парк жилдээ 20 тэрбум юанийн олдог төдийгүй нийтдээ 867 тэрбум юанийн бүтээмжтэй ажилладаг ажээ. Тэгвэл үйлдвэрлэлийн салбарын үндэс суурь нь гэгдэх Гуанжу (Кантон) хувцас, цахилгаан бараа бүтээгдэхүүн, хуванцар эдлэл, хүүхдийн тоглоом гээд тэнд үйлдвэрлэхгүй зүйл байхгүй. Canton Fair-р алдартай.

Гэхдээ Саудын Арабад дэлхийн хамгийн том аж үйлдвэрийн парк хот бий. Жубайл аж үйлдвэрийн хот Саудын Арабын зүүн мужид байрлах бөгөөд Ойрхи Дорнодын хамгийн том аж үйлдвэрийн парк хот юм. Түүнчлэн Ойрхи Дорнодын хамгийн том, дэлхийн дөрөв дахь том петрохимийн компанитай. Дэлхийн хамгийн том ус, эрчим хүчний бие даасан хамгийн том төлийг хэрэгжүүлж буй. Уг төслийн хүрээнд өдөрт 2700 гаруй МВ эрчим хүч, 800 мянган куб метр ус үйлдвэрлэдэг байна. ■



Зочин

Жеймс Робинсон: Институци гэдэг барилга барьж, түүнийгээ хүмүүсээр дүүргэнэ гэсэн үг биш

Б.ҮҮРИЙНТУЯА

Жеймс Робинсон АНУ-ын Чикагогийн их сургуулийн Харрисын нэрэмжит Төрийн бодлогын сургууль болон Богота дахь Андийн их сургуульд багшилдаг бөгөөд тэрбээр улс төрийн эдийн засаг, харьцуулсан улс төр, улс төр-эдийн засгийн хөгжлийн чиглэлээр Латин Америк, Африкийн Сахарын цөлөөс урагш орших орнууд болон Бүгд найрамдах ардчилсан Конго улс, Сьерра Леон, Гаити, Колумб зэрэг улсад судалгааны ажлуудаа чиглүүлдэг. Олон улсын түвшинд өндөр үнэлгээ авсан “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан: Эрх мэдэл, хөгжил цэцэглэлт, ядуурал” номоороо олны танил болсон тэрбээр Лондонгийн Эдийн засаг, улс төрийн сургуульд бакалавр, Варвикийн их сургуульд магистр, Иелийн их сургуульд докторын (PhD) зэрэг хамгаалжээ.

Тэрбээр Германы хамтын ажиллагааны байгууллагын Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулдаг “Чанартай өсөлт” цуврал лекцэд “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан: Эрх мэдэл, хөгжил цэцэглэлт, ядуурал” сэдвээр итлгэл тавихаар манай улсад ирсэн билээ. Бид түүнтэй энэ үеэр уулзаж ярилцсан юм.

-Та Монголд анх удаагаар ирж байгаа гэсэн. Сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Тийм ээ. Их сонирхолтой санагдаж байна. Улаанбаатарын амьдрал хэрхэн өрнөдөг, энгийн иргэд хэрхэн аж төрж буйг харахаар гэр хорооллоор явж үзлээ. Төрийн үйлчилгээний чанар, ус цахилгаанд холбогдсон эсэх, хотын хөгжил гэх мэт маш олон зүйл харлаа. Би Азиар мэргэшсэн хүн биш л дээ. Гэхдээ миний бага зэрэг мэдэх Казахстан,



Хятад зэрэг бүсийн бусад улстай харьцуулахад Монгол Улс гайхмаар өөр санагдаж байна. Би их зүйл сурч байна.

-Хотын төв дэх амьдрал захын хэсгүүдээс тэс өөр байна гэж үү?

-Байгалийн баялгийн нөлөөллөөс үүдэн нийгэм хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгааг нийгэмд үүссэн тэгш бус байдал илтгэж байна. Миний үзэж байгаагаар Монгол Улс одоо энэ их баялгийг зөв хуваарилан зөвхөн “Шангри Ла” зочид буудалд орох чадалтай хүмүүст биш, бүх хүнд хүртээмжтэй болгон аж амьдралыг нь өөрчлөхөд анхаарах хэрэгтэй.

-Үүнийг бид яаж хийх ёстой юм бол оо?

-Миний харж байгаагаар энэ асуудал нийгмийн институцитэй холбоотой. Эдийн засаг хийгээд улс төрийн системд боломж төдийгүй

идэвхжүүлэлтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх хууль, дүрмүүд хэрэгтэй байгааг харуулж байна. Улс төр, эдийн засгийн хүчирхэг институци бүхий улс орнууд байгалийн баялгийг нийгмийн сайн сайхны төлөө ашиглаж чадсан байдаг. Харин институцийн сул эсвэл дисфункциональ засаглалтай орнуудад эрдсийн баялаг нь хүртээмжгүй байх, тэр ч бүү хэл сөрөг нөлөөлөл үзүүлсэн жишээнүүд бий. Тэгэхээр Монгол Улсын хувьд байгалийн баялгаа хүн бүрт хүртээмжтэй байлгах зорилго бүхий институцийг бүтээх хэрэгтэй. Ийм шаардлага байгааг харуулж буй маш олон баримт байна.

-Энэ чиглэлд мэргэшсэн хүний хувьд Монголын институциудад ямар үнэлгээ өгөх вэ?

-Би улс төрийн институцид түлхүү анхааран ажилладаг. Миний хийж ▶

► байсан судалгаануудаас харвал эдийн засгийн хөгжлийг тодорхойлоход улс төрийн байгууллагууд тун чухал үүрэгтэй. Тэгэхээр зарим өнцгөөс харвал Монголын улс төрийн байгууллагууд сайн урагшилж байгаа. Монгол Улс 1990 онд өрсөлдөөнт ардчилсан системийг амжилттай байгуулсан. Яг үүнийг Монголыг хүрээлэх орнуудын жишээтэй харьцуулах юм бол ямар их амжилт вэ гэдгийг харж болно. Нийгэмд маш олон боломж нээж өгсөн үйл явдал гэж би хардаг. Энэ бол өнөөдөр ч үргэлжилсээр буй үйл явдал. Гэхдээ төрд улс төржилт, тогтворгүй байдал их байгаагийн улмаас бодлогын залгамж халаа үгүйлэгдэж байна. Улс төрийн томилгоо, эмх замбараагүй байдал их байна. Энэ чиглэлд анхаарч ажиллах хэрэгтэй.

Би Монголд иргэний нийгэм хэрхэн ажиллаж, хэр уялдаа холбоотой оршиж байгаа, мөн улс төрчдөөс хариуцлага нэхэх, ил тод байх тал дээр тэдэнд хэр нөлөөлж чадаж байгааг харахыг хичээж байна. Надад төрсөн сэтгэгдлээр бол тогтвортой байдалд хүрэхэд чухал гэгддэг зүйлсийн зөвхөн тал нь Монголд байна. Бусад чухал хүчин зүйлс үгүйлэгдэж байна. Иймд энэ тал дээр ахиц гаргах нь зүйтэй.

-Институцийн засаглал сул байгаа гэдэг утгаараа манай улс Африк, Латин Америкийн орнуудтай харьцуулагдах нь бий. Та үүнтэй санал нийлэх үү?

-Хувьдаа бол санал нийлэхгүй. Албадлага, иргэний сөргөлдөөн зэрэг Африкийн дийлэнх оронд байх улс төрийн тогтворгүй байдал Монголд байхгүй. Энд улс төрийн зохицуулалт харьцангуй сайн байгаа мэт санагдаж байна. Африктай харьцуулахад Монголд улс төрийн өрсөлдөх чадвар сайн байна. танай улсад социалист нийгэмтэй байх үед ч боломжууд нээлттэй байсан. Тухайлбал, боловсролын салбар, эмэгтэйчүүдийн оролцоо гэх мэт давуу талууд их байсан шүү дээ. Миний хувьд тухайн улсын нийгмийн түүх их чухал санагддаг. Энэ утгаараа Монголын улс төрийн түүхэн замнал Африк, Латин Америкийн орнуудынхаас их өөр. Харьцуулалт талаасаа бол сайтар тунгаах хэрэгтэй болов уу. Адилхан гээд хэлчих зүйл одоогоор олж хараагүй байна.

Монголчуудад өөрсдийн гэсэн онцлог шинж бий. Та бүхэнд өөрсдийн гэсэн хэл, соёл, үндэс угсаа бий. Энэ бүхэн үндэсний алсын хараа бий болгоход их дөхөм болдог. Нийгэмд

өгөөжтэй институциуд бий болгоход нийтээрээ санал нэгдэх асуудалд дээрх бүхэн маш чухал үүрэгтэй.

-Байгалийн баялаг арвинтай орон гэдэг талаасаа дээрх харьцуулалтыг хийдэг байж болох юм.

-Магадгүй. Уул уурхайгаас орж ирж буй асар том боломжуудыг хэрхэн ашиглах вэ гэдэг нь улс төрийн төдийгүй бусад институциас хамаардаг. Мэдээж сорилтууд бий боловч Монгол Улсад түүнээс давсан давуу талууд байна. Хэл соёл, ёс заншлын хувьд нэгдмэл зүйл их байгаа нь баялгийг удирдах институцийг бий болгох үндэсний төсөл хэрэгжүүлэхэд чухал давуу тал үүсгэнэ. Байгалийн баялгийн удирдлагыг маш сайн хийж чадсан Африкийн улс бол Ботсвана. Нэгдмэл хэл соёл, ёс заншилтай гэдэг утгаараа Монголтой төстэй. Тэгэхээр Монголыг Африкийн аль нэг улстай харьцуул гэвэл би Ботсвана гэж хэлнэ. Ботсвана институцийг амжилттай хөгжүүлж байна.

-Та “Улс үндэстний уналт доройтлын шалтгаан: Эрх мэдэл, хөгжил цэцэглэлт, ядуурал” хэмээх ном бичсэн. Улс орнуудын уналт, доройтлын шалтгаан нь юу байдаг вэ?

-Улс үндэстнүүд уналтад ордог гол шалтгаан бол нийгмийн сайн сайхны төлөө чиглээгүй хууль, хяналтын байгууллагын систем бий болгодогтой холбоотой. Ингэснээр улс төрийн хүчний хэт төвлөрөл үүсч, улмаар хэсэг бүлэг хүн бусдын төлөөсөөр хүчирхэгжиж монополь тогтоох нөхцөл бүрддэг. Үүнийг extractive институцийн тогтолцоо гэдэг. Энэ нь нийгмийг эрх баригч нөлөө бүхий хэсэг бүлэгт ашигтай байхуйцаар зохион байгуулж буйг хэлнэ. Институцийн ийм тогтолцоонд орсноор нийгэм доройтож, улс үндэстэн унаж эхэлдэг. Харин өргөн хүрээнд эрх мэдэл, боломж түгээдэг тогтолцоог inclusive гэдэг.

-Тэгвэл институцийн сайн зохион байгуулалтыг бий болгоход тулгардаг сорилтуудыг хэрхэн даван туулах вэ?

-Энэ бол улс төрийн процесс. Жишээ нь Монгол, Узбекистан хоёр юугаараа ялгаатай вэ? Узбекистаны төр диктатурын шинжтэй. 1980-аад оны сүүлээр коммунист намын гишүүд Зөвлөлтийн дараах төрийг эрхэндээ үлдээж чадсан. Ийм зүйл Монголд болоогүй. Коммунист төрийн эсрэг маш алдартай сөрөг хүчин босч ирсэн. Улмаар илүү нээлттэй улс төрийн

системд шилжсэн. Ийм зүйлс extractive-ээс inclusive тогтолцоонд шилжихэд дэм болдог. Төв Азийн олон оронтой харьцуулахад Монголд хүч хэрэглэх хүсэл огт байдаггүй нь сайшаалтай. Маш олон оронд шаардлага тавьсан хүмүүсийн эсрэг хүч хэрэглэн тэднийг дардаг. Харин Монголд коммунист дэглэмийн эсрэг хүмүүс Төв талбай дээрээ өлсгөлөн зарлаж байхад тэднийг ямар нэг байдлаар хүч хэрэглэн зогсоох гэж оролдоогүй байдаг шүү дээ. Үүнээс үзэхэд нийгэмд аливааг хүчээр шийдэх гэсэн хандалга байдаггүй нь харагдаж байгаа юм. Энэ бол үнэхээр гайхалтай хүч чадал.

-Институцийн зөв зохион байгуулалт бий болгох тал дээр монголчууд зөв замаараа явж байна уу. Эсвэл ангал руу ойртож байна уу?

-Өнөөг хүртэл амжилттай явж байна гэж бодож байна. Гэхдээ цаашид асар олон зүйл хийх хэрэгтэй. Украин зэрэг Зөвлөлтөөс задарсан орнууд зөв замаар урагшилж байсан мэт харагдаж байлаа. Гэтэл үгүй байж. Хэдийгээр Монголд ахиц ажиглагдаж байгаа ч институци, иргэний нийгмийг хөгжүүлэх, улс төржилтийг багасгах гээд гүйцэх ёстой ажлууд олон байна.

-Уналтад орж буй орнуудад ямар нийтлэг дүр зураг илэрдэг вэ?

-Монголд саяхан болсон нэгэн үйл явдлаар жишээлье. Улс төрийн намууд сонгуулийн системд өөрчлөлт оруулсан явдал. Өөрсдийн үйл ажиллагаанд давуу тал үүсгэх байдлаар өөрчлөлт хийж байгаа нь сайны дохио биш. Богино хугацааны ашиг сонирхлын үүднээс институциудыг аргачлах нь маш муу зүйл. Ийм байдлаар өөрчлөлт хийж болохгүй. Улс орныхоо хэтийн ирээдүйг бодох хэрэгтэй. Тэгэхээр улс төрчид улсад учирч болох үр дагаварыг золиослон богино хугацааны сонирхолд хөтлөгдөж байгаа явдал санаа зовоох шалтгаан мөн.

-Тэгвэл ахиц гарч байгаагийн илрэл нь юу байх уу?

-Монголын хувьд сонгуулийн дараа юу болохыг харах хэрэгтэй. Миний ажигласнаар эрх мэдэл гараа солиход удирдлагын шатны байгууллагуудад огцом эргэлт гарч байна. Шинэ хүмүүс орж, хуучнууд нь гардаг. Өмнө гарсан бодлогуудыг үргэлжлүүлдэггүй. Залгамж халаа дутмаг.

Төрийн үйл ажиллагааг зохицуулах хууль, дүрмүүд бодлогын залгамж халааг хангах хэрэгтэй. Тэгэхээр энэ ►

► зүйлд сайтар анхаарч, ахиц гаргах шаардлагатай.

-Монгол Улсад болон Монголын институцид тулгарч буй хамгийн том сорилтуудыг та юу гэж харж байна вэ?

-Байгалийн баялгийн менежмент хамгийн том сорилт юм болов уу гэж харж байна.

-Энэ чиглэлд цөөнгүй менежмент хэрэгжүүлж ирсэн. Гэвч алдаа оноо

бий болгохын тулд чадавхтай төртэй байх нь чухал. Үүнийг биелүүлэхийн тулд дадлага туршлагатай, зөв хүмүүсийг татан оролцуулах хэрэгтэй болохоос сонгуульд ялсан улс төрчдийн шуурганд хоморголоод байж болохгүй. Мөн аливааг хэрэгжүүлэхэд бэлэн байх хэрэгтэй.

-Институци гэдэг нь яг ямар ойлголтыг багтаадаг вэ?

-Хууль, дүрэм тогтоох. Энэ бол

нөлөөтэй.

-Сайн институцийг бий болгох ямар хүчин зүйлээс хамгийн их хамаардаг юм бол.

-Бэлэн байдал. Монголын иргэд хөгжил, цэцэглэлтээр дүүрэн улсад амьдрах хүсэлтэй байгаа гэдэгт итгэлтэй байна. Хүн бүхэн үр хүүхэддээ чанартай боловсрол эзэмшүүлж, амьдралын чанараа сайжруулахаар тэмүүлдэг. Гэвч ганцаараа энэ бүхэнд хүрэх нь боломжгүй мэт санагдаж, хүчгүйддэг. Ийм үед нийтийн зохион байгуулалтад ордог. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд үүнд маш чухал байр суурьтай оролцох хэрэгтэй. Ингэж байгаа үгүйг би мэдэхгүй. Гэхдээ тэднээс хамаарах зүйл их бий. Тэд санаачлага гаргаж, үлгэр дуралал үзүүлэх учиртай болов уу.

-Та төрийн бодлогоор мэргэшсэн хүн. Төрийн бодлого ямар байхаас улс орны хөгжил хамаардаг. Монголын төрийн бодлого таны бодлоор ямар түвшинд байна вэ?

-Макро, микро эдийн засгийн түвшинд төдийгүй нийгэм, улс төр гээд төрийн бодлого маш өргөн хүрээтэй. Тиймээс улс төржилтгүй, тогтвортой байх нь чухал. Монголын төрийн бодлогын тухайд өөрийн үзэл бодлоо хэлэх нь хэт өнгөц санагдаж байна. Учир нь би Монголд анх удаа цөөн хоногоор ирж байна. Гэхдээ ил тод байдал, хариуцлагын түвшинд авч үзвэл тодорхой хэмжээнд сайн үзүүлэлтүүд байна. Гэхдээ тун тааруу зүйлс ч ажиглагдаж байгаагийн нэг нь улс төржилт. Хэдий тийм ч дэлхийн зарим оронтой харьцуулахад зарим талаараа ахиж, дэвшиж байгаа нь сайн.

-Эцэст нь та монголчуудад хандаж зөвлөгөө өгөхгүй юү?

-Ирэх сард сонгууль тохиох гэж байна. Иргэд өөрсдөөсөө “Энэ сонгууль яг юуны тухай вэ?” гээд нэг асуух ёстой. Тэд нийгэм, олон нийтийн сайн сайхан болон төрийн бодлогод анхаарлаа хандуулах хэрэгтэй. Улс төрчид нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн бодлого ярьж байна уу эсвэл дэмжлэг авахын тулд нэг өдрийн тус хүргэх тухай ярьж байна уу гэдгийг онцлон авч үзэх нь чухал. Түүнээс биш “Намайг сонговол таныг ажилд оруулна” эсвэл “Танд юу хийж өгөх үү” гэсэн утгатай амлалт нийгэмд маш халтай. Улс төрчид улсынхаа хөгжил, сайн сайхны төлөө мэтгэлцэж байгаа эсэхэд анхаарах ёстой. ■



байснаа улс төрийн шилжилт хийгээд дөнгөж 20 гаруй жил болж байна гэж хаацайлдаг. Менежментийн хувьд манай улс хаанаас эхэлж, юунд анхаарах ёстой вэ?

-Институци болон ардчиллын чанарыг сайжруулахын зэрэгцээ төрийн үр ашгийг нэмэгдүүлж улс төржөөгүй, тогтвортой засаг бүрдүүлэх хэрэгтэй. Миний бодлоор Монголын төр их тогтворгүй байгаа нь анхаарах ёстой үндсэн асуудал. Эдийн засаг, нийгэмд төрийн сайн үйлчилгээ, тогтвортой байдал, урт хугацаанд хэрэгжүүлэх алсын хараа

барилга барьж, түүнийгээ хүмүүсээр дүүргэнэ гэсэн үг биш. Харин ардчиллыг тогтоож, өрнөх нөхцлийг бүрдүүлж, ардчиллын чанарыг сайжруулах тухай юм. Ингэхдээ ил тод байдал, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлж, иргэдэд эрхийг нь ойлгуулж, улс төрчдөд юу хийх ёстой вэ гэдгийг нь ойлгуулж, чиглүүлэх учиртай. Хууль байгаад хэрэгжихгүй бол ямар ч хэрэггүй. Тэгэхээр хууль, дүрмээ тогтоож түүндээ захирагдах нь чухал. Ингэж байж хүмүүсийн хүлээлт бас хандлага өөрчлөгддөг. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд асар их үүрэг,

“Mongolian Economy”-Гүнзгий мэд



Сэтгүүлчдийн эвлэлийн “2013 оны Шилдэг сэтгүүл”

Монголын бизнесийн зөвлөлийн

“Бизнесийн салбарын дэмжигч хэвлэл мэдээллийн
шилдэг байгууллага - 2012”

МУХАУТ-ЫН “Хэвлэлийн салбарын Оны онцлох
Entrepreneur-2011”

www.mongolianeconomy.mn

Үзэл бодол

Гадаад худалдаанд гарсан ахиц



Б.ТҮВШИН (Эдийн засагч)

Монголын эдийн засаг гадаад худалдаанаас их хамааралтай. Экспорт, импорт тус бүр манай ДНБ-ий 50 орчим хувьтай тэнцдэг бол БНХАУ, ОХУ, Япон, БНСУ зэрэг улсын хувьд эдгээр үзүүлэлт ДНБ-ийх нь 15-40 хувийг эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл, худалдааны гол түнш орнуудтай харьцуулж үзэхэд бид экспорт, импортоос илүү хамааралтай байгаа юм. Тиймээс ч ашигт малтмалын үнэ буурч, экспортын орлого хумигдахад Монгол Улс хамгийн их хохирол хүлээсэн.

Манай гадаад худалдаа 2006 оноос байнга алдагдалтай гарч байсан бөгөөд 2012, 2013 онд алдагдлын хэмжээ тус бүр хоёр тэрбум ам.доллараас давсныг графикаас харна уу. Энэ нь төлбөрийн тэнцлийн хямралд орох, гадаад валютын ханш өсөх суурь нөхцөл болсон гэж ойлгож болно. Мэдээж гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан нь дайран дээр давс нэмсэн. Харин 2014 онд Монгол Улсын гадаад худалдаа анх удаагаа 539 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд ашгийн хэмжээ өнгөрсөн жил 872 сая ам.долларт хүрч өссөн байдаг. Энэ оны эхний дөрвөн сарын гүйцэтгэлээс үзэхэд гадаад худалдааны ашиг өнгөрсөн жилийнхээс мөн л өсөх хандлагатай байна. Худалдааны тэнцэл ашигтай гарах нь гадаад валютын орох урсгал, хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн идэвхжил, өсөлтөд эргээр нөлөөлдөг сайн талтай.

Гэвч юунаас болоод манай гадаад худалдааны ашиг нэмэгдээд байна вэ гэдэгт анхаарлаа хандуулах нь чухал. Нэг талаас, дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ хямдарсантай холбоотойгоор Монголын экспортын орлого гурван жил дараалан буурч байна. Нөгөө талаас, дотоодод эдийн засгийн өсөлт саарсан, хөрөнгө оруулалт буурсан учраас импорт их хэмжээгээр багассан. Энэ нь улсын төсвийн татварын орлого тасрахад хүргэж, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.


Импортын бууралт

Импорт буурахад үндсэндээ гурван хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байна. Нэгдүгээрт, дэлхийн зах зээл дэх нефтийн ханш унаснаас манай импортын гол бүтээгдэхүүн болох түлш, шатахууны хилийн үнэ хямдарсан. Хоёрдугаарт, уул уурхайн төслүүд зогсонги байдалд орсон учраас үнэтэй тоног төхөөрөмж, машин механизм, түлшний импорт буурсан. Гуравдугаарт, гадаад валютын ханш огцом өссөнтэй холбоотойгоор импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, монголчууд хэрэглээгээ танахаас өөр аргагүй болсон. Гэвч нэг хаалга хаагдахад нөгөө хаалга нээгддэг гэдэгчлэн импорт багассанаар дотоодын үйлдвэрлэгчдэд боломж олдсоныг анзааралгүй өнгөрч боломгүй.

Нэг үеэ бодвол монголчууд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ нэлээд хэсгийг үйлдвэрлэж чаддаг болчихлоо. Импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг төрийн бодлогоор бага зэрэг дэмжсэний үр дүн ч гарч эхэлжээ. Тухайлбал, цементийн импорт өнгөрсөн жил 40 хувиар буурсан бол энэ оны эхний дөрвөн сард дахиад 60 гаруй хувиар багассан байна. Монгол Улсын Хөгжлийн банкаас дотоодын цементийн үйлдвэрүүдэд санхүүжилт олгож дэмжсэний ашиг тус энэ юм. Үүний адил өндөг, тахиа, гахайн мах, зөгийн бал, сүү, сүүн бүтээгдэхүүн зэргийн импорт ч буурч байгаа нь сайн хэрэг. Одоо дотоодод үйлдвэрлэж байгаатай ижил төрлийн импортын бараанд тарифын зохицуулалт хийж эхэлсэн нь валютын гадагшлах урсгалыг зогсоож, тэр хэрээр эх орныхоо эдийн засагт шингээх зорилготой юм. Энэ нь Монголын хувьд нэг том дэвшил боловч хийх ажил хэтэрхий их байна.

Валютын гадагшлах хамгийн том урсгалыг хаахын тулд бид түлш, эрчим хүчний хэрэгцээгээ өөрсдөө хангаж эхлэх ▶

Гадаад худалдаа, сая ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Валютын гадагшлах хамгийн том үрсгалыг хаахын тулд бид түлш, эрчим хүчний хэрэгцээг өөрсдөө хангаж эхлэх ёстой. Монголчууд зөвхөн өнгөрсөн онд л гэхэд нефтийн бүтээгдэхүүнд 707 сая ам.доллар, цахилгаан эрчим хүчинд 129 сая ам.доллар зарцуулсан нь нийт импортын 30 гаруй хувийг эзэлсэн байна.

► ёстой. Монголчууд зөвхөн өнгөрсөн онд л гэхэд нефтийн бүтээгдэхүүнд 707 сая ам.доллар, цахилгаан эрчим хүчинд 129 сая ам.доллар зарцуулсан нь нийт импортын 30 гаруй хувийг эзэлсэн байна. Энэ их валютыг гадагш гаргалгүй дотооддоо үлдээхийн тулд нүүрс, газрын тосоо боловсруулж, сэргээгдэх эрчим хүчний нөөцөө зөв зохистой ашиглах хэрэгтэй.

Экспортын төрөлжилт

Монгол Улс 120 гаруй улстай худалдаа хийж байгаа гэдэг. Гэвч яг практик дээр манайд Хятад гэсэн ганц л зах зээл бий гээд хэлчихэд буруудахгүй. Тиймээс ч урд хөршийн эдийн засгийн өсөлт саарч, ашигт малтмалын эрэлт хэрэгцээ багассан нь манайд шууд нөлөө үзүүлсэн. Гэхдээ сүүлийн гурван жилд экспортын маань Хятадаас хамаарах байдал бага багаар буурч байна.



2012 онд манай нийт экспортын 93 хувь нь зөвхөн Хятад руу гарсан бол өнгөрсөн онд энэ үзүүлэлт 84, энэ жилийн эхний дөрвөн сард 82 хувь болтлоо буурсныг графикаас харна уу. 2011 онд дээд цэгтээ хүрч байсан нүүрс, зэсийн үнэ түүнээс хойш байнга хямдарсантай холбоотойгоор Монголын экспортын үнийн дүн багассан нь ийм байдалд хүргэжээ. Гэвч

үүнтэй зэрэгцээд БНСУ, Швейцарь зэрэг бусад улс руу гаргах экспортын хэмжээ нэмэгдсэн нь эдийн засаг солонгорох найдлага төрүүлэх болов. Ер нь ашигт малтмалын үнэ унасан нь муу хэрэг боловч сайн үр дагавар ч байна. Нүүрс, зэсийн орлого багасаад ирэхээр төр ч,

хувийн хэвшлийнхэн ч уул уурхайгаас бусад салбарт анхаарч, эдийн засгаа төрөлжүүлэх чиглэлээр ажиллаж эхэлсэн. Тухайлбал, өнгөрсөн жилээс хүнсний бараа, бүтээгдэхүүний, тэр дундаа махны экспорт мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Урд, хойд хөрш рүү гаргах махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр төр засгийн зүгээс бичиг цаасны ажлыг цэгцэлсний үр дүн эхнээсээ гарч байгаа нь энэ болов уу. Гэвч бас л хийх ажил хэтэрхий их байна.

Монголчууд түүхий эд гаргах биш, нэмүү өртөг шингэсэн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортолж байж л хөгжиж чадна. Мэдээж хэрэг асар том хэмжээний кокс химийн, эсвэл гангийн үйлдвэр босгоод ирэх хөрөнгө мөнгө бидэнд одоогоор байхгүй. Харин эхний ээлжинд арьс ширээ цүнх, гутал болгоод, ноос ноолуураа цамц, малгай ороолт болгоод гаргачих боломж, нөхцөл бий. Зах зээл нь ч бэлэн байна. Манайх Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийснээр 130 сая хүнтэй тэр том зах зээлийг үндсэндээ нээчихсэн. Тиймээс монголчууд япончуудад тохирсон бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх боломжоо ашиглахад анхаарах хэрэгтэй.

Эцэст нь

Монголын эдийн засаг гадаад худалдаанаас, харин гадаад худалдаа маань Хятадын зах зээл, тийшээ нийлүүлэх ашигт малтмалын үнэ ханшаас хэт хараат байна. Тиймээс ч эдийн засаг маань их эмзэг байдаг бөгөөд зэс, нүүрсний үнэ унах төдийд л хямарчихдаг. Үүнийг өөрчлөх гэж байгаа нь энэ гээд нүүрс, зэсээ Хятад руу гаргааа больчихож болохгүй. Одоохондоо биднийг тэжээж байгаа ганц орлого шүү дээ. Сүүлийн 20 гаруй жилийн турш бүрэлдэж, ужгирсан буруу бүтцийг ганц хоёрхон жилийн дотор өргөс авсан мэт засчихна гэж юу байх билээ. Тиймээс нүүрс, зэсээ зардгаараа зараад, харин тэр орлогоо зөв зохистой удирдах, уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлэхэд л анхаарах хэрэгтэй. Энэ нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардах ажил байх нь гарцаагүй. ■